

# ЦАХИМ ОРЧИНД ҮЙЛДЭГДСЭН ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ҮЙЛДЛИЙН АРГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS RESULTS OF THE METHODS OF FRAUD IN THE CYBER ENVIRONMENT



## П.Эрдэнэбаатар\*

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хурандаа

Pol. Col. Erdenebaatar P, Senior Lecturer, Department of Criminal Procedure Law, Police School, University of Internal Affairs

## Б.Цогтбаатар

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн захидал бөгөөд Дотоодын цэргийн 804 дүгээр ангийн захирагч, доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

Pol. Col. Tsogtbaatar B, Assoc. Prof, Ph.D, Director, Police School and Commander of the 804th Unit of Internal Troops, University of Internal Affairs

\*Хариуцлагатай зохиогч: purewerka5@gmail.com

УЧИЛГААНЫ ТӨВӨГТЭЙ ҮЙЛДЛИЙН АРГЫН ДҮН

**Хураангуй:** Энэхүү судалгааны хүрээнд цахим орчинд үйлдэгддэг залилах гэмт хэргийн үйлдлийн аргуудыг судалж, дүн шинжилгээ хийсэн болно. Технологийн хөгжил сайжрах тусам залилах гэмт хэргийн аргууд нарийн төвөгтэй болж, хамрах хүрээ нь улам өргөжиж байна. Судалгаанд дурдсан залилах гэмт хэргийн аргууд ихэвчлэн хохирогчийн сэтгэл зүй, итгэл дээр тулгуурлаж, цахим платформуудын сүл талыг ашиглах байдлаар хэрэгждэг. Үйлдэгдэж буй аргуудыг тухайллан судлаагүйгээс цахим орчинд хяналт тавих, гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагаанд бэрхшээл тулгарсаар байгаа нь сэдвийг судлах үндэслэл болсон билээ.

Сэдвийн хүрээнд манай улсад болон гадаад улс орнуудад үйлдэгдэж илрээд байгаа цахим орчны залилах гэмт хэргийн үйлдлийн аргыг тухайллан гаргаж, нэгтгэн дүн шинжилгээ хийж, манай улсад хэрэгжүүлэх бодлогын баримт бичигт тусгал болгон авч үзэх, цаашдын судлаач нарын ажилд дөхөмтэй үзүүлэлтүүдийг нээн харуулахыг зорилго болгов.

Судалгааны ажил нь бүтцийн хувьд удиртгал хэсэгт криминалистикийн онолын болон цахим орчны залилан мэхлэх гэмт хэргийн хор уршгийг цахим сүлжээтэй холбоотойгоор авч үзээд, үндсэн хэсэгт гадаад дотоод үйлдлийн аргуудыг тодорхойлон харьцуулж, онцлогийг илэрхийлэн, дүн шинжилгээг хийсэн, дүгнэлт хэсэгт үр дүнгийн багц ойлголтыг тодруулан, санал хэсэгт дүгнэлтээс урган гарсан шийдвэрлэх арга замыг зөвлөмжилсөн болно.

Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийн аргууд байнга өөрчлөгдөж, нарийн төвөгтэй болж байгаа нь судалгааны хүрээг өргөжүүлэх шаардлага үүсгэсэн бөгөөд манай улсаас гадна олон улсад илэрч судлагдсан энэхүү гэмт хэргийн үйлдлийн түгээмэл аргуудыг авч үзсэн болно.

Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийн аргуудыг судлахдаа олон улсад илэрч судлагдсан үйлдлийн аргуудыг манай улсынхтай харьцуулах замаар дүн шинжилгээ хийж нэгдсэн түгээмэл аргуудын жагсаалт гаргаж, тухайлсан арга тус бүрийн онцлогийг нээн харуулж байгаа нь судалгааны ажлын үр дүнг илэрхийлнэ.

**Abstract:** This study examines and analyzes the operational methods of online fraud. As technology advances, methods of fraud are becoming more sophisticated and broader in scope. The methods of fraud described in the study often rely on the psychology and trust of the victim and exploit the weaknesses of online platforms. Due to the fact that the methods used have not been studied, there are still difficulties in monitoring the online environment, detecting, stopping, preventing, and investigating crimes, which is the reason for studying the topic.



ХУУЛЬ САХИУЛАХҮЙ

Within the scope of the topic, the methods of fraud in the electronic environment that have been detected in our country and foreign countries have been identified, analyzed and considered as a reflection in the policy documents to be implemented in our country, and the indicators that are useful for the work of future researchers have been revealed.

In terms of structure, the research work is considered in the introductory part of forensic theory and the harmful effects of cyber fraud in relation to the Internet, in the main part, external and internal operational methods are compared, expressed and analyzed, in the conclusion part, the set of concepts of the results is clarified, and in the proposal part The solutions resulting from the conclusions are recommended.

It is concluded that by studying the cases of fraud in the online environment based on the method of operation, it will contribute to the development of future prevention and individual and common prevention policies.

The methods of fraudulent crimes committed in the electronic environment are constantly changing and becoming more complex, which has created the need to expand the scope of research, and the popular methods of this crime, which have been studied in other countries as well as in our country, are considered.

When studying the methods of fraudulent crimes committed in the electronic environment, the results of the research work are expressed by analyzing and comparing the international methods of operation with those of our country, making a list of common methods and revealing the characteristics of each method.

In the research, the data analysis of the General Police Department, the analysis of the fraud crime situation of the last 10 years conducted by the operational management office (CEG, Analysis of the situation of "fraud" crime, 2023) and the fraud crime committed using electronic means in Mongolia. Common methods are selected and explored by sampling from the "Methods" menu of the Common Crime Foundation.

The results of the research will be used for further monitoring, detection, suppression, prevention, and investigation of crimes by studying and comparing them, clarifying their features, and summarizing the methods of cyber-fraudulent crimes that have been detected in our country and foreign countries. It is defined as a combination of theory and practice to be considered in major policies.

**Түлхүүр үг:** Гэмт хэргийн үйлдлийн арга, фишинг, сайтыг хуулбарлах арга, интернэт-худалдаа, кардинг буюу зээлийн карт ашигла

**Keywords:** Forms of crime, phishing, website cloning, e-commerce, credit card fraud, scams.

### Удиртгал

Криминалистикт гэмт хэргийн үйлдлийн аргыг тодорхойлох нь болж өнгөрсөн бүхий л нөхцөл байдлыг нэг бүрчлэн тогтоож, мөрдөн шалгах ажиллагааны зорилгыг хэрэгжүүлэх ач холбогдолтой гэж тайлбарладаг. Тухайлбал, Гэмт хэрэг үйлдэх арга нь “зөвхөн аливаа нэг үйлдлүүдийн нийлбэр, аль эсвэл ердийн нэг иж бүрдэл төдий биш, харин тодорхой хэмжээний бүтэц, зан төлөвийн шинж чанарыг өөртөө агуулсан бүхэл бүтэн тогтолцоо (Карпов Н. М., 2003, хувд. 108)” гэж тодорхойлсон байна. Тогтолцооны бүтцийн онцлог нь “гэмт

хэрэгт бэлтгэх, үйлдэхээр завдах, үйлдэх, гэмт хэргийн ул мөрөө баллахад чиглэсэн зан үйлийн өөр хоорондоо холбоотой бүрдэл” хэсгүүдийг бий болгож байдагт оршино.

Судалгаанд Цагдаагийн Ерөнхий Газрын Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас залилах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн сүүлийн 10 жилийн дүн шинжилгээ (ЦЕГ, “Залилах” гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн талаар, 2023) болон Монгол Улсад үйлдэгдэж байгаа цахим хэрэгсэл ашигласан залилах гэмт хэргийн нийтлэг аргуудыг Эрүүгийн хэргийн нэгдсэн



МОНГОЛ УЛСЫН ЦАХИМ ОРЧИНД ҮНДСЭН ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН АШИГЛАН

сангийн “үйлдлийн арга” цэсээс түүвэрлэх замаар сонгон судалсан болно.

Монгол Улсад цахим хэрэгсэл ашиглан үйлдсэн залилах гэмт хэргүүд өссөн (үзүүлэлтийг энэ судалгаанд графикаар харуулсан) бөгөөд гэмт этгээдүүд иргэдийн итгэл үнэмшлийг төрүүлэхийн тулд үйлдлийн олон талт арга ашиглаж байгаа нь харагддаг ба энэ талаар цаашид анхаарал хандуулах шаардлагатай гэж үзэн судалгаа, дүгнэлт хийв (ЦЕГ, “Залилах” гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн талаар, 2023).

Цахим ертөнц нь мэдээллийг түгээх, дамжуулах олж авах, ашиглах, солилцох, орон зайд бий болгох үүрэг гүйцэтгэхээс гадна бизнес, эдийн засаг, банк санхүү, шинжлэх ухаан, боловсрол, нийгмийн харилцааг агуулсан өргөн сонголттой, ашиглахад хялбар, цаг хугацаа хэмнэсэн, газар нутаг, орон зайн алслалтаас үл хамааралтай, эрх зүйн зохицуулалтын өргөн агуулгатай талбар гэдэгт судлаачид нэгддэг.

Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэрэг нь ихэвчлэн зохион байгуулалтад шилжсэн, дэлхийн аль ч улс орноос цахим сүлжээ ашиглан үйлдэгддэгээрээ онцлогтой.

Монгол Улсын хэмжээнд цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийн үйлдлийн аргын талаарх харьцуулсан судалгааны ажил тухайлан хийгдээгүй гэж үзэх үндэслэлтэй бөгөөд энэхүү судалгаа нь цаашид цахим орчинд үйлдэгдсэн залилах гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах, энэ төрлийн судалгааг гүнзгийрүүлэн хийхэд ач холбогдолтой гэж үзлээ.

Манай улсын төр захиргаа, олон нийтийн байгууллага, хувийн хэвшил, иргэн үл харгалзан дээрх халдлагад өртөж, сүүлийн таван жилийн хугацаанд энэ төрлийн гэмт хэрэг 25,849-д хүрсэн. 2023 онд гэхэд дээрх гэмт хэргийн улмаас 87.5 тэрбум төгрөгийн хохирол учраад байна (Цахим хөгжил, 2024). Үүний ихэнх нь энгийн иргэдийг чиглэсэн халдлага байсан. Нэр бүхий компани, төрийн байгууллагын нэрийг барьж, хуурамч өгөгдөл, линк, тоглоомоор дамжуулан

иргэд, хуулийн этгээдийг хохироосон үйлдлийд бүртгэгдсэн. Ингэхдээ иргэдийн цахим шуудан, мессенджер, утасны дугаар руу мэдээллээ илгээхээс гадна реклам сурталчилгаагаар дамжуулан иргэдийг олзодог.

Монгол Улсын газар нутагт сервергүй, гадаад улсад сервер нь байршилтай “facebook, instagram, gmail, yahoo” зэрэг цахим сүлжээний хэрэгслийг манай улсын иргэд өдөр тутамдаа ашигладаг. Судалгаанаас үзэхэд цахим орчинд хуурамч хаягаас хандалт хийж, цахим хэрэгсэл, цахим сүлжээ ашиглах аргаар үйлдэгдсэн гэмт хэргийн 30 орчим хувь нь “Facebook” мэдээллийн сүлжээ ашиглан үйлдэгдэж, 95.6 хувийг (ЦЕГ, 2023) залилах гэмт хэрэг эзэлдэг. Иймд иргэд цахим хэрэглээний талаар ойлголт, мэдлэг, дутмаг аюулгүй байдлын дүрэм, журам, стандартыг хангаж хэрэгжүүлдэггүй, эдийн засаг, эрх зүйн мэдлэг хангалтгүй байдаг нь гэмт хэрэгт өртөх үндсэн шалтгаан болдог гэж дүгнэх үндэслэл илэрч байна. Энэхүү судалгааны зорилго нь цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн аргуудыг тодорхойлон, Монгол Улсад илрүүлэх, урьдчилан сэргийлэх бодитой арга хэмжээг санал болгоход оршино. Уг судалгааг хийхдээ Монгол Улсын цахим залилах гэмт хэргийн нөхцөлд байдалд хийсэн тоо баримтыг авч үзэн, мөн Монгол Улсад үйлдэгдэж буй цахим залилах гэмт хэргийн үйлдлийн аргуудыг гадаад улсад үйлдэгдэж буй цахим залилах гэмт хэргийн нөхцөл байдал, олон улсын жишээтэй харьцуулан авч үзсэн болно. Судалгааны явцад Монгол Улсад үйлдэгдэж байгаа цахим залилах гэмт хэргийн үйлдлийн арга олон улсад үйлдэгдэж байгаа цахим гэмт хэргийн үйлдлийн аргуудад ижил төсөөтэй шинжүүд ажиглагдсан. Гэмт хэргийн хохирлын харьцаагаар авч үзвэл Монгол Улсын цахим залилах гэмт хэргийн дундаж хохирол эдийн засгийн үзүүлэлтэй харьцуулахад ихээхэн өндөр байгаа нь бодлогын өөрчлөлт шаардлагатайг харуулж байна.

### Үндсэн хэсэг



МОНГОЛ УЛСЫН ХОХИРОГЧИЙН НАСААНЫ СҮРГҮҮЛЧЛЭЛ

Цахим залилах гэмт хэрэг нь мэдээллийн технологийн эрин үед дэлхий даяар хурдацтай өсөж буй гэмт хэргийн нэг бөгөөд энэ нь тухайн улсын хил хязгаарыг даван дэлхийн аль ч улсаас үйлдэгдэх боломжтой гэдгээрээ онцлогтой. Энэ утгаараа дэлхий дахинд үйлдэгдэж буй нийтлэг цахим залилах гэмт хэргийн аргууд нь Монгол Улсад ч мөн адил үйлдэгдэж байна. Сүүлийн үед Монгол Улсын иргэдийг телеграмм болон бусад олон нийтийн сүлжээгээр гадаад улсын нутаг дэвсгэрээс цахимаар залилах үйлдэл их хэмжээгээр гарч байна. Телеграммаар гэхэд сүүлийн 4 сарын хугацаанд 10.3 тэрбум төгрөгийн бодит хохирол иргэдэд учирсан (П.Сайнжаргал, 2024). Цахим залилах гэмт хэргийн энэхүү хил дамнасан шинж чанар нь зөвхөн нэг улсын бус, дэлхий нийтийн асуудал болсныг батална. Иймд Монгол Улсын нөхцөл байдлыг олон улсын жишигтэй харьцуулан судлах нь зүйтэй гэж үзэв.

Оросын Холбооны Улсын судлаач, Карпов, Н.С, Мозоль, А.П. нар “Гэмт үйлдэл нь тодорхой дэс дараалал, үе шатыг дамжин тухайлсан зорилгоо хэрэгжүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын шинжийг агуулсан байдал” (Карпов Н. М., 2003, хууд. 108) гэж тэмдэглэсэн нь цахим орчинд үйлдэгдсэн залилах гэмт хэргийн үйлдлийн аргыг тодорхойлоход тус дөхөм юм.

Цахим орчинд гэрээ, хэлцэл, тохиролцоо үйлдсний үр дүнд мөнгө шилжүүлсэн ч хүлээн авагч нь нутаг дэвсгэр болон харьяаллын хувьд тодорхой бус байх нь элбэг тохиолддог. Үүний улмаас маргаантай асуудал гарсан тохиолдолд хохирогчийн зөрчигдсөн эрхийг нэг улсын хууль тогтоомжоор шийдвэрлэхэд хүндрэлтэй байдалд ордог нь олонх судалгаанаас илэрхий болсон. Гэмт хэрэг хоёр өөр улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэнээр хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа амжилттай явагдах магадлал буурч, залилагч этгээд нотлох баримтайгаар гэм буруутай нь нотлогдсон ч

- Хохирогчид нөлөөлөн, цахим
- шуудангаар мэдээлэл солилцон бичилт хийх арга (Larson, 2024);

эруүгийн хариуцлага хүлээлгэх боломж хязгаарлагдмал болсоор байна.

Ийм нөхцөл байдлыг дараах жишээнээс харж болох юм. Тодруулбал, сүүлийн үед үйлдэгдсэн цахим орчны залилах хэрэгт “гэмт этгээд өөрийнхөө сайтыг интернэт сүлжээнд байршуулан түүнийгээ ашиглан садар самуун сурталчилсан зураг, видео материал худалддаг. Тухайн сайтаар зочилж байгаа хохирогчид өөрийнх нь зээлийн картын тухай мэдээлэл багтсан асуумж бүхий анкетыг бөглөх замаар бүртгэл үүсгэж дээрх нэр бүхий зураг, материалыг үзэж танилцах эрхтэй болохоор ойлголт төрүүлж, тэрхүү үйлдэлд хөтөлсөн бөгөөд тухайн сайтаар зочилж байх хооронд нь тэрхүү байгууллага данснаас нь багахан хэмжээний суутгалыг төлбөрийн журмаар татан авна. Энэхүү төлбөр нь хохирогч үл тоох хэмжээний бага байх учир тэр бүр анзаараад байдаггүй. Картын мэдээлээ алдсан хохирогчийн данснаас гэнэт их хэмжээний мөнгө алдагдаж, хохирогч хохирсон тухайгаа мэдсэн ч гэсэн залилан мэхлэгчдийн бурууг нотлох ямар нэг арга байхгүйн дээр тухайн сайт залилах үйлдлээ нэгэнт гүйцэтгэсэн тул хаагдсан” (Эрүүгийн хэргийн материал, 2023) жишээг дурдаж болно.

Судалгааны дээрх баримтаас үзэхэд залилан мэхлэгч чухам хэн бэ гэдэг нь тогтоогдох боломжгүй, нууцлагдмал хэвээрээ үлдэж, өөр бусад улс орон, нутаг дэвсгэрийн хохирогчдыг залилах боломж нь нээлттэй хэвээр үлддэг. Энэ нь интернэт сүлжээ ашиглаж байгаа залилан мэхлэгчдийн бодит боломж, хохирол учруулах үр дагаврын илэрхийллийн цар хүрээг харуулж байна. Дурдсан хэргийн баримтыг шинжлэн үзэхэд хохирогчдын ихэнх нь өөрийн улсын хууль сахиулах байгууллагад ханддаггүй, хэрхэн гомдол гаргахаа мэдэхгүй нөхцөл байдал тулгарч байгаагаар дүгнэж болно.

Цахим орчинд залилах гэмт хэргүүдийг дараах бүлгүүдэд хуваан үзэж болно. Тухайлбал,

- Төрөл бүрийн сайт ашиглан
- нууцлалтай код, дугаар, нууц

түлхүүрт олзлох замаар залилах гэмт үйлдэх арга;

Цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэрэг нь мэдээллийн технологи, техник, тоон төхөөрөмж (Халтар, 2019, хувд. 15), тоон электроник буюу дижитал электроник (Википедиа, 2022) программ хангамж, ашигладгаараа ердийн залилах гэмт хэргээс ялгаатай. Тодруулбал, Хохирогчид мэдэгдэхгүй байх нууц далд байдлыг бүрэн хэмжээгээр хангах, Ижил төсөөтэй байдал үүсгэн олон тооны хохирогчдыг амжилттайгаар төөрөгдөл оруулах зэргийг дурдаж болно.

Цахим орчинд залилах гэмт хэрэг үйлдэхийн тулд гэмт этгээд нь загвар, бүдүүвч, төлөвлөгөө боловсруулан электрон хэрэгсэл, цахим сүлжээгээр дамжуулан өөрт ашигтай боломжуудыг хэрэглэдэг.

Монгол Улсын хэмжээнд цахим орчинд залилах гэмт хэрэг үйлдсэн аргыг бүдүүвч хувилбараар нь ялан 2010-2023 онд хийгдсэн судалгааны (ЦЕГ, мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны танилцуулга, 2023) үр дүнд дүн

шинжилгээ хийж үзэхэд түгээмэл ашиглагддаг аргад “Бизнесийн зээл олгох арга”, цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн 21% буюу хамгийн өндөр хувийг, хонжворт сугалаа явуулах арга 19%, цахим тоглоом ашиглах аргаар үйлдэгдсэн гэмт хэрэг 14%, цахим орчинд танилцан дотносож итгэл олж авсны дараа дансаар мөнгө авч залилах аргаар үйлдэгдсэн гэмт хэрэг 15%, хувийн нууцтай холбоотой цахим гэмт хэргийн төрлүүд болох Кардинг буюу банкны картын мэдээллийг ашиглах, эмзэг мэдээлэл хулгайлж авах Фишинг, Романс залилан, цалин хөлс нэмэгдүүлэх сонирхол дээр тогтолт хийх аргууд тодорхой хувийг эзлэсэн. Сүүлийн жилүүдэд койн буюу криптовалют, үнэт цаас зэргийг ашиглан цахим орчинд залилах гэмт хэргийн тоо эрс нэмэгдэх болсон. Энэ төрлийн арга нь харьцангуй хожим үүссэн боловч хурдацтайгаар өөрчлөгдж, улам нарийн аргыг ашигласаар байна. (График 1-ээс үзнэ үү).



МОНГОЛ УЛСЫН ХАДААЛАЛЫГ БҮРДЭХ ЦАХИМ ОРЧИНД ҮЙЛДЛЫН АРГУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ

**Цахим орчинд үйлдэгдсэн залилах гэмт хэргийн үйлдлийн аргуудын эзлэх хувь  
(Монгол Улс 2010-2023 он )**



График.1 Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргүүдийн эзлэх хувь

Судалгаагаар тогтоогдсон, зонхилон үйлдэгдэж байгаа цахим орчны залилах гэмт хэргийн үйлдлийн аргыг тухайлан авч үзэхэд дараах онцлогтой.

Уг судалгааг хийхдээ Монгол Улсын цахим залилах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн тоо баримтыг “Залилах” гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж (Цагдаагийн ерөнхий газар, 2023) авч үзсэн. Мөн Монгол улсад

үйлдэгдэж буй цахим залилангийн үйлдлийн аргуудыг дэлхийн улс орнуудын цахим залилах гэмт хэргийн нөхцөл байдал, олон улсын жишээтэй харьцуулсан аргачлалаар хийсэн болно (Mazurina Mohd Ali, 2022). Судалгааны явцад Монгол улсад үйлдэгдэж байгаа цахим залилах гэмт хэргийн үйлдлийн арга олон улсад үйлдэгдэж байгаа цахим гэмт хэргийн үйлдлийн аргуудад ижил төсөөтэй



МОНГОЛ УУДААСАН ХУУЛЬ САХИУЛАХАЙ

шинжүүд ажиглагдсан. Гэмт хэргийн хохирлын харьцаагаар авч үзвэл Монгол Улсын гарч байгаа цахим залилангийн дундаж хохирол эдийн засгийн үзүүлэлттэй харьцуулахад ихээхэн өндөр байгаа нь бодлогын өөрчлөлт шаардлагатайг харуулж байна.

Цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийг өмнөх болон одоо үетэй харьцуулсан хувилбарыг доорх байдлаар боловсруулав.

Өмнөх үеийн нийтлэг арга барилууд (2000-2010)

#### 1. Цахим шуудангийн фишинг:

- Гэмт этгээдүүд цахим шуудангаар хуурамч банкны мэдэгдэл, хожлын мэдээлэл илгээж, хохирогчийн хувийн болон санхүүгийн мэдээллийг авахыг оролддог байсан.
- Жишээ нь, “Нигерийн хунтайж”-ийн түүх буюу томоохон хөрөнгө өвлөж авахад туслахыг хүссэн мессежүүд түгээмэл байсан.

1. Вирус болон тандах(spyware) программ ашиглах:

- Компьютерийн вирус илгээж, хохирогчийн мэдээлэлд хяналт тогтоох.
- Энгийн программ хангамжийг ашиглан банкны гүйлгээг хуурамчаар хийх.

#### 2. Хуурамч онлайн худалдаа:

- Интернет худалдааны сайтууд дээр хуурамч бараа бүтээгдэхүүн зарж, хохирогчдыг мөнгөө урьдчилан шилжүүлэхийг шаардаа.

Одоо үеийн нийтлэг арга (2010-2023)

1. Хуурамч платформ болон апликэшн ашиглах:

- Гэмт этгээдүүд санхүүгийн апликэшн, криптовалютын хуурамч платформ үүсгэж, хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх нэрийдлээр залилан хийдэг.
- Жишээ нь, криптовалютын залилангийн платформ ашиглан

хэрэглэгчдийн хөрөнгийг хулгайлах.

#### 2. Сошиал медиа ашиглан залилах:

- Facebook, Instagram, TikTok зэрэг сошиал медиа платформуудыг ашиглан хуурамч профайл үүсгэж, мөнгө зээлэх, хандив хүсэх үйлдэл өргөн тархсан.

- Романс залилангийн хохирогчдыг сэтгэл зүйн нөлөөлөл, холбогдолд оруулж, санхүүгийн хохирол учруулах.

#### 3. Хиймэл оюун ухаан ашиглан залилан мэхлэх:

- Deepfake технологи ашиглан хуурамч дурс бичлэг, аудио үүсгэж, албан тушаалтны нэр барьсан, аль эсвэл хуурамч хүний дүрээр танилцаж залилах үйлдлүүд илэрдэг.

- Chatbot ашиглан хэрэглэгчидтэй бодит мэт яриа өрнүүлж, хувийн мэдээллийг хуурч авдаг.

Харьцуулалт:

- Өмнөх үе: Харьцангуй энгийн, технологийн хувьд бага ноён ашиглан үйлдэгддэг байсан ба фишинг болон вирусын халдлагууд давамгайлж байв.

- Одоо үе: Илүү нарийн төвөгтэй, технологийн дэвшлийг ашигласан залилан мэхлэх аргууд гарч ирж байна. Сошиал медиа, хиймэл оюун ухаан, криптовалют зэрэг шинэлэг технологиуд түгээмэл болжээ.

#### 1. Кийн буюу криптовалют залилан (Udit Agarwal, 2023)

Хуурамч төсөл, койнууд гаргах эсвэл зохиомол үнийн хэлбэлзлийг бий болгох замаар мэдлэг, мэдээлэлгүй иргэдийг их хэмжээгээр хохироох, иргэдийн худалдан авсан койныг хуурамч хэтэвч (wallet) рүү шилжүүлж гадаадын болон дотоодын бирж рүү арилжаалж, шилжүүлэг хийсний дараагаар оп сураггүй алга болох. Энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд маш хүндрэлтэй бөгөөд учир нь



МОНГОЛ УЛСЫН  
ХААНТЫН СИСТЕМЫН  
ДАВЧИНЫН  
СОГДЫН  
СИСТЕМЫ

крипто данс нь мөрдөн мөшгөх, данс эзэмшигчээс өөр хэн нэгэн этгээд хувийн мэдээллийг нь олох боломжгүй. Жишээлбэл, гэмт этгээд харилцах банкны дансандаа мөнгө шилжүүлэн авсан тохиолдолд мөрдөгч банк руу хандаж данс эзэмшигчийн мэдээллийг авах боломжтой атал криптовалют нь блокчэйн технологи дээр суурилсан байdag ба энэ нь банк санхүүгийн байгууллага болон дундын зуучлагчгүйгээр өндөр нууцлалын технологийн дагуу гүйлгээ хийгддэг. Данс эзэмшигч нь өөрийн нууц үгээ мартсан эсвэл нууцлал бүхий хамгаалалтын түлхүүрээ мартсан тохиолдолд өөрөө ч ахиж хэзээ ч нэвтэрч чадахгүй болох эрсдэлтэй байдаг.

#### 2. Романс залилан (Federal Bureau of Investigation, 2024)

Цахим орчинд харилцаа тогтоон хүний итгэлийг олж авах, улмаар үүнийгээ ашиглан залилах гэмт хэрэг үйлдэхийг романс залилан (*romance scam*) гэж тодорхойлдог. Тодруулбал, романс залилангиин гэмт хэрэг нь цахим орчинд танилцаж, хайр сэтгэлийн холбоо тогтоон тухайн хүний итгэлийг нь олж авч, хохирогчтой удаан хугацаанд харилцан, худал мэдээлэл өгч мөнгө, эд хөрөнгө шилжүүлэн авах үйл явцыг илэрхийлдэг. Энэ төрлийн гэмт хэргийг хиймэл оюун ухаан ашиглан үйлдэх нь ихсэж Deepfake буюу “гүн хууралт” (Osipilli Aparna, 2023) гэх нүүр царайг дуурайлган зураг, бичлэг, дуу хоолой хийх технологийг ашиглах шинэ арга барил дэлгэрээд байна.

Уг технологи нь хангалттай өгөгдлийг өгснөөр хүссэн хүнийхээ гадаад төрх байдал, хөдөлгөөнийг, дуу хоолойн хамтаар дуурайлгаж тухайн боловсруулсан дүрс болон дуу бичлэгийн мэдээллээ хохирогч руу илгээн хуурч, өөрт хэрэгтэй мэдээллийг авах, өндөр дүнтэй мөнгөн гүйлгээ заасан дансанд хийлгэх, тодорхой үйлдлийг хийлгэх зэрэг ашиглаж байна. Эдгээр технологи нь хуурамчаар дүрд нь орох гэж буй хүнтэйгээ ойролцоо биеийн галбиртай хүнийг сонгож, зөвхөн нүүрний хэсгийг өөрчлөх аль эсвэл тэр чигт нь хийсвэрээр хуурамч бичлэг хийх боломжтой байдаг.

Монгол Улсад романс залилангийн төрлийг илрүүлэхэд гадаад серверүүдтэй хамtran ажиллах зохицуулалтыг сайжруулах шаардлагатай. Тухайлбал, цагдаагийн байгууллага гадаадын платформуудтай харилцах эрх зүйн болон техникийн механизмыг боловсронгуй болгох нь оновчтой шийдэл юм.

3. Цахим орчинд захидал солилцох (Investopedia, 2023)

Хохирогчид нөлөөлөх үндсэн хэрэгсэл болгох зорилгоор цахим шууданг (чат бичих-мэдээлэл солилцох) ихэвчлэн ашигладаг.

Мэдээлэл солилцох IMS (*Instant Messaging Service*) гэж олон улсад нэршигдсэн “шуурхай мессежний үйлчилгээ”-г гэмт санаа бодлоо хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл болгон ашигладаг. Ийм гэмт хэргийн гол шинж нь хохирогчийг төөрөгдөл оруулан захидал бичих бөгөөд зарим тохиолдолд зөвхөн ганц захидал бичих нь залилан мэхлэгчийн хувьд хангалттай байх тохиолдол ч бий.

Гэмт этгээд ирээдүйн хохирогч болох хүмүүс, хуулийн этгээдийн санхүүгийн болон бусад нууц мэдээлүүдийг вирусийн программ хангамж ашиглан анкет, асуулга авах зарчмаар ч олж авдаг.

Цахим сүлжээ ашиглан үйлдэж байгаа залилах гэмт хэргийн түгээмэл хэрэглэгдэж байгаа нэг төрөл бол гадаад орнуудад “нигериин захидал” хэмээн нэрлэж байгаа цахим шууданд тулгуурласан арга юм. Энэ арга интернэт сүлжээ үүсэхээс бүр өмнө үүссэн хэдий ч өнөөгийн нөхцөлд хэрэгжсээр байна. “Нигериин захидал”-ын гол санаа нь дараах байдлаар илрэдэг. Тухайлбал, дэлхийн өнцөг бүрд илгээгддэг, хэн нэг нь захильтыг хүлээж аваад уншиж үзвэл ихэвчлэн англи хэл дээр бичигдсэн (Grigutyté, 2023) байдаг, агуулгатай танилцвал улс орных нь дотор үүссэн эмх замбараагүй явдлын улмаас санхүүгийн зарим нэгэн түр зуурын бэрхшээл үүсээд байгаа нигериин нэгэн баян эрхэм өөртөө тусламж хүссэн агуулгатай байх ба тэрээр өөр нэгэн улс руу өчүүхэн төлбөр шилжүүлэх шаардлагатай байгаа талаараа дурсан энэ хүсэлтийг нь



ХУУЛЬ САХИУЛАХАЙ

биелүүлж өгсний хариуд их хэмжээний мөнгөн урамшуулалт амласан байдаг. Захидал илгээгчийн зүгээс тавьж буй цорын ганц нөхцөл нь бэрхшээлд ороод байгаа баян нигерийн шаардсан мөнгийг шилжүүлэн байршуулах, цаашлаад илүү их хэмжээний шаардлагатай төлбөрийг нь нэр бүхий улс руу шилжүүлээд илүү нэмэгдэлтэй дүнг өөрт нь шагнал болгон эргүүлж шилжүүлэх болзолтойгоор банкин дахь төлбөрийн дансны дугаараа өгдөг. Дансны дугаараар нь мөнгө явуулсны дараа харин бүх үйлдэл эсрэгээрээ явагдаж залилуулсан хохирогчийн данснаас мөнгө нь хаашаа ч юм шилжиж эргэж шилжих хөдөлгөөн хийгдэхгүйгээр алга болдог.

Олон улсын байгууллага, түүний дотор НҮБ-аас үлэмж хэмжээний мөнгийг дансанд нь шилжүүлэн байршуулахад бэлэн байгаа мэт угтатай мэдээлэл бүхий мессеж тараах үзэгдэл ажиглагдаж байна. Энэхүү аргыг нийгмийн сүлжээг ашиглан залилах арга гэх бөгөөд хэрэглэгчийн программ хангамжийг түр хугацаагаар гэмтээх замаар хэрэглэгчийн хаяг руу хууль бусаар нэвтэрч хэрэглэгчийн “найз”-ын жагсаалтад байгаа хэн нэгэн лүү хэрэглэгчийн нэрийн өмнөөс тусгайлсан агуулгатай захидалыг явуулан мөнгө асуух байдлаар хэрэглэгдэж эхэлж байна. Энэ аргын нэг онцлог нь хохирогч залилагч этгээдтэй нийгмийн сүлжээнд найз болсноор өөрт захидаар ирсэн линк руу нэвтрэн орж, нэр бүхий программыг өөрийн төхөөрөмждөө суулгаснаар хувийн мэдээллээ алдан, улмаар өөрөө ч мэдэлгүйгээр хохирогч болж энэ нь даамжирч өөрийн ойр тойрны хүмүүсээ залилуулсаар байдаг онцлогтой нь судалгаагаар илэрсэн.

#### 4.Зээлийн карт(кардинг) ашиглах (money smart, 2024)

“Кардинг” гэдэг нэр томьёо нь банкны картыг эзэмшигчийн зөвшөөрөлгүй ямар нэг хэлбэрээр ашиглаж байгаа залилах гэмт хэргийн шинэ төрлийг хэлнэ. Гэмт этгээдүүд хохирогчийн төлбөр тооцооны “Web Money, Pay Pal” зэрэг системд хууль бусаар нэвтрэн, эсвэл зөөврийн компьютерыг нь шууд удирдахын тулд алсаас нэвтрэх программ ашиглах,

вирусийн программ суулгах гэх мэт замаар нэвтрэн орж, төлбөрийн картын мэдээллийг өөрийн болгодог. Түүний зэрэгцээ кардинг нь олон янзаар хэрэгжүүлж болох загварчлалаараа ялгаатай. Ямар төрлөөр илэрсэн байх нь хамаагүй бөгөөд кардинг бол орчин үеийн мэдээллийн технологи ашигладгаараа аюул дагуулж байдаг. Кардинг нь нэг талаас цахим орчинд үйлдэгддэг залилан мэхлэх гэмт хэргийн нэгэн төрөл, нөгөө талаас зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд өөрийн гэмт санаа бодлоо хэрэгжүүлэх зорилгоор бусдад итгэл, ойлголт төрүүлэх явдлаар илэрхийлэгддэг. Тухайлбал, хуурамч зээлийн карт үйлдвэрлэх, бэлэн бус гүйлгээг бэлэн мөнгө болгон хувиргах, хуурамч үйлчилгээний төв, сайт зохион байгуулах, ажиллуулах зэргээр илэрч байна.

#### 5.Мэдээллийн сайт ашиглах (norton, 2024)

Мэдээллийн сайт ашиглах цахим гэмт халдлагын хэлбэр нь энэ төрлийн гэмт хэргийн дийлэнх хэсгийг эзэлдэг онцлогтой.

Судлаачдын үзэж байгаагаар залилан мэхлэгч нарын үйл ажиллагаанд дор дурдсан хувилбарууд түгээмэл илэрдэг. Тухайлбал,

- 1)Хөрөнгө оруулалтын загварчлал;
- 2)Цалин хөлс;
- 3)Шидэт түрийвч;
- 4)Нээлттэй дуудлага худалдаа, интернэт-худалдаа;
- 5)Онлайн-казино, хонжворт тохирол;
- 6)Сайтуудыг хуурамчаар хуулбарлах зэрэг ордог.

Энэ хувилбаруудаас нээлттэй дуудлага худалдаа буюу цахим-худалдааг нарийвчлан судалж үзэхэд энэ нь хуурамч сайт үүсгэн тэндээ элдэв төрлийн бараа материал зарж буй дүр үзүүлж худалдан авалт хийсэн хүмүүсээс ашиг олох замаар үйлдэгддэг. Тухайлбал, ямар нэгэн эд хөрөнгө борлуулах нэрийдлээр хохирогчоос захиалгын төлбөрийг урьдчилан шилжүүлэн аваад барааг нийлүүлэхгүй байх явдлаар илэрнэ. Залилан мэхлэгч нарын дуудлага

худалдааны үед хэрэглэдэг хоёр үндсэн арга байна. Үүнд:

- Тухайн барааны өмнөх худалдан авагч нь татгалзахад “хоёр дахь боломж” олдож байгаа мэтээр 1) дуудлага худалдаанд оролцуулж веб сайтын нэрийг хамт явуулах. Тухайн хаягаар шаардлагатай мөнгийг шилжүүлснээр хохирогч болох.

Онлайн-худалдаагаар дагнадаг залилан мэхлэгч нар “дуудлага худалдаачид”-аас ялгаатай нь өөрийн

1) Аль болох олон худалдан авагчийг өөртөө татахын тулд эрэлт ихтэй барааг хямдруулсан интернэт-дэлгүүр байгуулах арга. Төлбөрөө төлсөн хүнд ямар ч бараа илгээмжээр ирэхгүй.

Хохирогч тухайн сайтад зочилж байх үед “өөрчлөгдөх боломжтой үнэ тогтоох” арга. Зөвхөн хохирогчид зориулсан барааны үнийг бий болгох. жишээ нь: чанараас нь хамаарч байгаа гэх үндэслэлээр ялимгүй өсгөх байдлаар худалдан авах сонирхлыг ихэсгэх зорилготой, зарим нөхцөлд үнэ нэмж байгаа нь дэлгүүрийн захирагааны зүгээс ижил нэр бүхий дуураймал бүтээгдэхүүн худалдан авахаас хохирогчийг урьдчилан сэргийлж байгаа хэрэг гэж тайлбарлах нь бий.

Дээрх төрлийн аргыг хэрэгжүүлэх нэг чухал нөхцөл бол бэлэн бус хэлбэрээр төлбөр тооцоо хийх боломжийг олгох юм. Хэрэглэгч нь тухайн сайтын хувийн мэдээлэл оруулах хэсэгт асуултад хариулах замаар бүртгүүлснээр хохирогч болдог.

Бүртгүүлсний дараа хохирогч өөрийн сонирхсон барааг захиалахын тулд банкны зээлийн карттай холбоотой мэдээллийг төлбөр тооцоо хийх үүднээс залилан мэхлэгчид мэдээлснээр урхинд орно. Хохирогч нь цахим орчинд үйлдэгддэг залилах гэмт хэргийн талаар ямар нэг мэдээлэлгүй, туршилагагүй, анхаарал болгоомжгүй, хайхрамжгүй нэгэн байвал зээлийн картын мэдээллийг илүү нарийн мэдэх зорилгоор залилан мэхлэгч янз бүрийн шалтгаан хэлж бусад мэдээллийг нэмэлтээр олж авдаг. Үүний дараагаар хохирогчийн данснаас барааны үнэ, тээврийн зардал, хүргэлтийн төлбөр

- Дуудлага худалдаанд оролцхон сонирхол бүхий хүмүүст төлбөрийн дансаа баталгаажуулахыг мэдэгдэх 2) арга. Нэвтэрсэн веб сайт нь хуурамч эцсийн дундээ хохирогч өөрийн нууц мэдээллийг гэмт этгээдэд шилжүүлдэг.

зорилгоо хэрэгжүүлэх залилах олон төрлийн аргатай байна. Эдгээрийг тоймлон харуулбал, Үүнд:

3) Санхүүгийн боломж, нийгэмд эзэлж байгаа байдал зэргийг харгалzan ирээдүйн хохирогч нарт нууцаар ялгавартай хандах арга. Энэ арга нь үйлчлүүлэгчийнхээ талаар дэлгэрэнгүй данс, тооцоо хөтөлдөг компаниуд орно. жишээ нь: аяллын компаниуд залилах арга болгон хэрэглэгддэг. Нэрсийн жагсаалт, бусад тандалтыг үндэслэн нэг ижил ажил үйлчилгээнд янз бүрийн үнэлгээ тогтоож төлбөрийг урьдчилан авахад чиглэгдсэн байdag.

Гэх мэтчилэн гүйлгээ хийгддэг. Залилан мэхлэгч захиалсан барааг тодорхой хугацаанд захиалагчид хүргэлтээр ирэх учрыг тайлбарлаж өгөөд хохирогч хүлээх хэрэгтэй болдог. Залилан мэхлэгч түүний зээлийн картын хэрэгцээт мэдээллийг авч банкны дансанд шилжиж орсон мөнгийг аван өөр данс руу хийдэг. Зарим тохиолдолд захиалгыг биелүүлдэг боловч бараа нь анх захиалсан шиг нь байх, ижил загварын бараа боловч гэмтэл, гологдолтой бүтээгдэхүүн байх тохиолдол байdag. Зээлийн карт ашиглан дээр дурдсан сул талуудаар дамжуулан гэмт хэрэг үйлдэж байна.

Цахим орчинд нийгмийн сүлжээ ашиглан залилах гэмт хэрэг үйлдэх аргын нэгэн дэд хувилбар болох сайтуудыг хуулбарлах арга нь гэмт этгээдүүд интернэтийн сүлжээг ашиглан ялгах аргагүй сайт хийдгээрээ онцлог.



МОНГОЛ УСГЫН ТӨЛБӨРИЙН ААНЫ СОНIRХOL



МОНГОЛ УУДААСАН ХУУЛЬ САХИУЛАХУЙ

## 6. Цалин хөлс нэмэгдүүлэх сонирхол дээр “Тоглолт хийх” (Seon, 2024)

Хүмүүсийн цалин хөлсөө нэмэгдүүлэх сонирхол дээр үндэслэн “тоглолт хийх” аргыг өргөн хэрэглэж байна. Энэ аргыг хэрэгжүүлэх байдал нь олон янз байдаг. Ерөнхий ойлголт авахын тулд дараах жишээтэй танилцаж болох юм. Нэр алдар бүхий нэг номын сангийн “Ховор номын сан”-д байгаа номыг хуулбарлаж, дахин хэвлэх ажилд өндөр цалин хөлс амлаж байгаа сайтыг зохионо. Энэ төрлийн сайтад байрлах санал нь тухайн саналын бодит үнэний талаар ирээдүйн хохирогчид ямар ч эргэлзээ төрүүлэхгүйгээр боловсруулагдсан байдаг. Энэхүү саналд ном хуулбарлах, дахин хэвлэх техник ажиллагааны талаар шинжлэх ухааны үндэслэлтэй уг өгүүлбэр зориуд сонгогдсон байх нь хохирогчийг төөрөгдөл оруулах үндсэн аргуудын нэг нь болно. Сонирхож буй нэгэнд тавигдах цорын ганц шаардлага нь цаашид түүний хийж гүйцэтгэх ажилтай нь холбоотой харилцаа холбоо, тээвэр зэрэгт шаардлагатай мөнгийг шилжүүлэх санал тавьдаг. Үүний дараагаар заилиан мэхлэгч нь хохирогчоос өөрийн хүссэн мөнгөө олж авмагц, вэбсайтаа хаагаад алга болдог.

Энэ тохиолдолд заилиан мэхлэгчид төлж байгаа төлбөрийн хэмжээ нь төдийлөн ихгүй байдаг учраас тухайн гэмт хэргийг мөрдөн шалгахад үлэмж бэрхшээл гардаг. Учир нь хохирогчийн дийлэнх хувь нь хууль сахиулах байгууллагад энэ талаар гомдол гаргадагтүй, гомдол гаргасан зарим тохиолдолд нэхэмжиж байгаа мөнгөний хэмжээ нь хуульд заасан эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж мөрдөн шалгах ажиллагаа явуулах хохирлын хэмжээнд хүрэхгүй байгаа үндэслэлээр хэрэг

- 1) Мэдээллийг олонд нэр хүндтэй 2) банк, эсвэл банк санхүүгийн байгууллагын нэрийг барин тараах.

Зарим тохиолдолд мэдээлэл тараахын оронд цахилгаан холбооны хэрэгсэл ашиглан утсаар дуудлага хийдэг. Энэ аргыг ихэвчлэн ямар нэг банкны суурин сүлжээнд хулгайгаар нэвтрэх, тэнд

бүртгэлтийн хэрэг нээхээс татгалздагт оршино.

## 7. Картын мэдээллийн нууцлалыг авах “фишинг” (Cisco, 2024)

Картын мэдээллийн нууцлалыг авах “фишинг” аргын үндсэн зорилго бол хохирогчоос шаардлагатай нууц мэдээллийг нь “дэгээдэх” явдал учраас энэ аргыг “фишинг” буюу англи хэлний “phishing” дэгээдэх гэдэг үгээр оноон нэрлэсэн байдаг.

Орчин үед шинээр үүсэн бий болж байгаа “Зээлийн карт(кардинг) ашиглах арга”-ын өөр нэгэн төрөл болох “фишинг” буюу картын мэдээллийг олж авах арга” нь цахим төрлийн гэмт хэргийн баагүй хувийг эзэнлэ. Энэ арга нь ойрын ирээдүйд төлбөрийн картын мэдээллийг хулгайллах замаар нийгэмд дэлгэрч байгаа бөгөөд цаашид нийтлэг хэрэглэгдэх арга болж хувирах магадлалтай. Үндсэн арга нь хэрэглэгчийн итгэлийг урвуугаар ашиглан банкны сайттай төсөөтэй хуурамч сайтыг зохион түүгээр дамжуулан хохирогчийн төлбөрийн картнаас бэлэн мөнгө хулгайллах гэмт хэрэг юм.

Картын мэдээллийн нууцлалыг авах “фишинг” аргын онцлог шинж нь мэдээлэл солилцох үйлчилгээ болон сайт зохиохоос гадна харилцаа холбооны сүлжээ, ашиглах, тэдгээрийг хослуулан нь хэрэглэдэг. Картын мэдээллийн нууцлалыг авах “фишинг” арга нь банк хоорондын тооцоо эсвэл зээлийн картаар хийх гүйлгээний нууцлалын талаарх мэдээлэл олж авахыг зорих ба түүнийг ашиглан мөнгө хулгайллах үйлдэлд шилждэг хууль бус үйлдэл юм. Цахим орчинд захидал солилцох аргатай адил мэдээлэл тараах боловч дараах ялгаатай. Үүнд:

Мэдээлэлд ямар нэгэн сайтын нэрийг заавал дурдсан байх ба жинхэнэ сайтын хуулбарлан хэрэглэгчийг заилиан мэхлэгчид хэрэгтэй тусгайлан бэлдсэн хэсэг рүү дагуулах.

ажилладаг өөрийн талын хамтрагчаас тухайн хохирогч болгохоор сонгосон хүний зээлийн картын талаарх зарим нэг мэдээллийг олж авсан тохиолдолд хэрэглэдэг. Энэ аргын гол нууц нь



МОНГОЛ УСАГДЫН НАСНЫ ХЯЗГААРЛАЛТЫН ЦАГХААРЛАН

хэрэглэгч ямар нэг асуудлаар банканд хандахад ихэнх тохиолдолд автомат хариулагчид холбогддог байдлыг овжиноор ашиглахад оршиж байна. Тухайн тохиолдолд залилагч этгээд автомат хариулагчийн дүрд “хувилж” “Таны зээлийн картыг хууль бусаар ашиглах гэсэн оролдлого гаргадаг тул гүйлгээг нь түр “хаах-блоклох” шаардлага гарлаа. Иймээс танд мессежээр илгээх дугаар луу өөрийн “нэвтрэх нууц дугаар-пин”- кодыг илгээнэ үү” гэх байдлаар хэрэгжүүлдэг.

#### 8.Хонжворт сугалаа явуулах (Central Bank, 2024)

Энэ арга нь хуурамч хонжворт тохирол зохиох юм. Ингэхдээ хохирогч болох хүний гар утсанд хонжворт тохирлоор “та утасны дугаар хонжворын эзэн боллоо, “автомашин хожлоо” гэх мэт мессеж ирүүлэх болно. Мессежинд тухайн шагналыг олгох компанийн сайтын хаяг дурдагдсан байх, түүгээр орж шагнал авах нөхцөлийнхөө талаар мэдэж болох тухай мэдээлсэн байна. Үүгээр үүрэн холбооны үүрэг дуусгавар болно. Харин нэр бүхий сайтад хандсанаар та шагналд авах машиныхаа даатгал болон хүргэлттэй холбоотой зардал болох тодорхой хэмжээний мөнгийг шилжүүлэх тухай зааврыг аван, түүнийг нь шилжүүлтэл хүлээн авсан тухай хариу ирэхгүй байх ба тун удалгүй шагналаа авах ямар ч боломжгүй гэдгийг ойлгоно. Харин тэрхүү сайт нь мэдээж хуулбарлаж зохиосон байх тул таны мөнгийг өөрийн болгох боломжтой данс руу хийлгэх зорилготой.

#### 9.Өрөвдүүлэх замаар мөнгө гүйх “Буяны сан” (Australian Competition and Consumer Commission, 2024)

Өрөвдүүлэх замаар мөнгө гүйх “Буяны сан” арга нь залилан мэхлэгч нэр бүхий бодит хүний гадаадад хийлгэх өндөр үнэтэй мэс ажилбар түүний зардал, нөхөн сэргээх эмчилгээ, сувилаанд зориулсан хандив цуглуулах тодорхой хаягтай цахим орчин дах сайтыг яг ижил байдлаар нь зохиож, хаяг шошгыг дуурайлган үйлдэж дансны дугаар байршуулан хандивын хэмжээг бага байхаар заан өөрийн дансанд авах гэмт хэрэг юм.

#### 10.Бизнесийн зээл олгох (Home Business, n.d.)

Техник, технологи хөгжихийн хэрээр хиймэл оюун ухааны технологи нь гэмт хэрэгтнүүдэд залилах гэмт хэрэг үйлдэх илүү таатай боломжийг бүрдүүлж, иргэдийн хувийн мэдээллийг хулгайлсан, ашиглах замаар залилах гэмт хэргээ илүү амжилттай үйлдэх боломжийг бий болгосон. Гэмт хэрэгтнүүд хүмүүсийн анхаарлыг татах, залилан мэхлэгчдийг халхавчлах зорилгоор хохирогчдыг залилах гэмт үйлдэлд татан оролцуулдаг. Жишээлбэл, “Хувьцааны зөвлөмж” гэсэн залилах гэмт хэргийн үеэр залилан мэхлэгчид хэд хэдэн худалдаачдаас “Хувьцааны зөвлөмж” гэж нэрлэгдэх олон тооны дансыг худалдан авчээ. Хувьцааны зөвлөмжийн мэдээллийг зорилтот бүлэгт илгээн, хохирогчдыг хөрөнгийн зах зээлд уруу татсаны дараа тэднээр өндөр гишүүнчлэлийн хураамж төлүүлж, программ хангамж худалдаж авхуулж, шинэ хуурамч арилжааны платформтойгоо танилцуулна. Энэ төрлийн гэмт хэргийн ард хохирогчоос бусад нь хууран мэхлэгч байх ба, олон хүнийг хөрөнгө оруулалтад оруулахын тулд та идэвхтэй оролцох хэрэгтэй гэсэн хурмаг байдлыг бий болгон хохирогч болгодог.

#### 11.Цахим орчинд тоглох-тоглоом (HDFC, 2024)

Сүүлийн жилүүдэд цахим орчинд хүмүүс мөрийтэй тоглоом тоглох тохиолдлууд эрчимтэй тархаж байна. Цахим орчинд тоглоом тоглогчийн тоо эрс өсөж, тоглоом зохиогчдын тоо ч тасралтгүй нэмэгдсэн. Цахим орчинд тоглох тоглоомыг вирусийн программ хангамжтай хоршуулан үйлдлийн аргаа нарийсгаж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Цахим орчинд тоглох-тоглоомын аргыг боловсруулж байгаа этгээд нь программ хангамж, тоглоомыг тоглуулах, ашиглах ур чадвар, мэдлэг, мэдрэмж мэдээлэл тодорхой хэмжээний санхүүгийн боломжтой байгаа нь ажиглагдсан. Тоглоом тоглогчдын дуинд наасны хязгаарлалт байхгүй, санхүүгийн боломжтой, тоглох цаг хугацааны хувьд ямар нэг байдлаар хязгаарлагдмал бус



МОНГОЛ УУДААСАН ХУУЛЬ САХИУЛАХАЙ

хүмүүст чиглэгдэнэ. Тэдний дундаас онлайн-тогооны ирээдүйн хохирогчийг тодруулна. Цахим орчинд тоглох-тогоомын арга нь тогоомоос олох ашиг орлогын төлөө цаг хугацаа, эд хөрөнгөе зарцуулах хүсэлтэй хүмүүсийг татахад чиглэгдэнэ.

1. Картын мэдээллийн нууцлалыг авах “фишинг” аргыг ашиглах;
2. Тоглогчдын тоглоомд нууц үгийг нь хулгайлах;

#### 12. Насанд хүрэгчдийн кино сайт ашиглах (FBI, 2024)

Цахим орчинд насанд хүрэгчдийн сайтаар залилах гэмт хэрэг үйлдэхэд зохион байгуулалттай бүлэглэл оролцохгүй байна гэж байхгүй бөгөөд “системд халдах, онлайнаар залилах” гэмт хэргүүдийг ганц нэг хүн үйлдэх боломжгүй. Энэ төрлийн гэмт хэргийг үйлдэгч этгээдүүдийн бусад төрлийн зохион байгуулалттай гэмт бүлэглэлээс ялгагдах ялгаа нь бүлгийн гишүүд дэлхий даяр тархан байршин хилийн чанд дахь улс оронд тархсан байдал. Уг гэмт хэрэгтнүүдийн үйлдэж байгаа гэмт хэрэгт захирах, захирагдах ёс үйлчилдэггүй байна (МУИС, 2013, хууд. 82).

Орчин үед цахим орчинд зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд оролцох болсны улмаас нэг хэрэгтний үйлддэг байсан бага хохиролтой гэмт хэргүүд нь их хэмжээний хохиролтой, олон улсыг хамарсан, илүү ярвигтай зохион

- |                                     |   |   |
|-------------------------------------|---|---|
| 1.                                  | 2.  | 3.  |
| Товчон сэдэлжүүлэх агуулгатай байх. | Аль болох их итгэл үнэмшилтэй байх, Нийгмийн ямар нэг сүлжээ ашиглаж байгаа бол захидалыг өөрийн хүрээллийн аль нэг найзаасаа хүлээн авч байгаа мэт сэтгэгдэл төрүүлэхүйц байх. | Цахим орчинд үйлдэж буй үйлдэл нь гэмт хэрэг биш мэт харагдах, нуун далдах шинжийг агуулсан байх. |

Монгол Улсад цахим орчинд үйлдлийн залилах гэмт хэргийн үйлдлийн гүйцэтгэсэн аргыг судлан авч үзэхэд (ЦЕГ, Залилах гэмт хэргийн нөхцөл байдалд дун шинжилгээ хийсэн талаар тайлан, 2023):

- 33.3 хувь нь онлайн бараа бүтээгдэхүүн худалдан борлуулах нэрээр;
- 23.1 хувь нь хохирогчийн танил хүний мэдээллийг ашиглаж;
- 21.4 хувь нь эх сурвалж тодорхойгүй цахим хаягт байршуулсан бага

Касперский лабораторийн мэргэжилтнүүдийн судалгаагаар онлайн-тогоомын нууц мэдээллийг хулгайлдаг дараах үндсэн аргууд (securelist by kaspersky, 2024) байна. Үүнд:

3. Вирусийн программ

байгуулалттай, үйлдвэржсэн гэмт хэргүүд болон хувирч байна (Moore, 2016, pp. 32(3):3-4.). Тухайлбал, Монгол Улсаас хөөгдөн гарсан 800 хятад иргэдийн цахим орчинд үйлдсэн гэмт хэргийн үйлдэл үүнд орно. Монгол Улсад үйлдэгдэж байгаа цахим гэмт хэргийн 80 хувь нь зохион байгуулалттай шинжтэй гэж судлаачид үзсэн. (University & London, 2014)

Европолын “ЮОСТА” илтгэлд дурдсанаар ойрын ирээдүйд цахим орчинд үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа үндэстэн дамжсан шинжийг агуулж, цахим орчинд мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий байгууллагууд олон улсын түвшинд хамтран ажиллах шаардлагатай гэж дурджээ. (UNODC, 2013)

Судалгааны дүнгээс үзэхэд энэ үйлдлийн арга нь үндсэн гурван шинжтэй. Үүнд:

- 3.

хүүтэй зээл олгох зарын дагуу мөнгө шилжүүлсэн;

- 8.5 хувь нь гадаад улс руу зорчих виз гаргаж өгөх нэрийдлээр;

- 4.3 хувь нь гадаад улсын цахим платформд үүсгэсэн цахим хэрэгсэлд бүртгүүлж мөнгө шилжүүлэх;

- 1.7 хувь нь ажилд зуучилж өгнө, урьдчилгаа төлбөр авна гэж;

- 0.9 хувь нь гадаад улсын валют худалдан авахаар мөнгө шилжүүлэн авах;



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГААСЫН ЦАХИМ ОРЧИНД ҮЙЛДЭГДЭХ БҮЙ ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН АРГУУД ТЕХНОЛОГИЙН ХӨГЖЛИЙГ ДАГАН ИЛҮҮ НАРИЙН ТӨВӨГТЭЙ БОЛЖ, ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГАУУДАД БОДЛОГЫН ШИНЖТЭЙ БОЛОВСРОНГҮЙ НАРИЙН АРГА ХЭРЭГСЛИЙГ НЭВТРҮҮЛЭХ ШААРДЛАГЫГ БИЙ БОЛГОЖ БАЙНА. УРҮДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХАД ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГАЫН ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ ЧУХАЛ ЮМ.

2. Цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн аргууд технологийн хөгжлийг даган илүү нарийн төвөгтэй болж, хууль сахиулах байгууллагуудад бодлогын шинжтэй боловсронгүй нарийн арга хэрэгслийг нэвтрүүлэх шаардлагыг бий болгож байна. Урьдчилан сэргийлэх, хяналт тавихад хууль сахиулах байгууллагын технологийн дэвшлийг нэмэгдүүлэх нь чухал юм.

3. Монголын Улсад энэ төрлийн гэмт хэргийн аюул заналтай үр дүнтэй тэмцэж чадахгүй байгаа нь олон тооны хохирогч бүртгэгдэж, тэдгээр нь хохирлоо барагдуулж чадахгүй, гэмт хэрэг ессөөр, үйлдлийн арга төгөлдөршиж, гадаад улсын элдэв гэмт аргын хувилбар нэмэгдсээр байгаад дүгнэлт хийх цаг нэгэнт болжээ.

4. Монгол Улсын хувьд өнөөгийн байдлаар бодит, хийсвэр эдийн засгийн харилцан хамаарлын асуудал нь эрх зүйн шинжлэх ухаанд бүрэн судлагдаагүй байгаа учраас цахим орчинд залилах гэмт хэргийн үйлдлийн аргын судалгааг практик нөхцөлтэй холбож илүү гүзгийрүүлэн суурь судалгаа хийх шаардлагатайг харуулж байна.

### Санал

- Манай улсын хувьд цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, үр дүнтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулах, урьдчилан сэргийлэхийн тулд олон улсын хамтын ажиллагааг сайжруулж, тухайлсан гадаадын зарим улстай санхүүгийн болон авлигын эсрэг конвенцын хүрээнд эрх зүйн туслалцааны гэрээ байгуулах замаар криптовалютын зах зээлийн зохицуулалтыг боловсронгүй болгох, гадаад серверүүдтэй хамтран ажиллах механизм хэрэгжүүлэх шаардлага урган гарч байна.

- Цахим орчинд үйлдэгдсэн залилах гэмт хэргийн үйлдлийн аргуудад үндэслэсэн сургалтын богино хугацааны хөтөлбөр боловсруулан үр дүнтэй мөрдөн шалгахад чиглэгдсэн сургалтуудыг аймаг, нийслэлийн, сум дүүргийн цагдаагийн газар, хэлтсүүдийн мөрдөгч нарт зохион байгуулах, үүнд Кибер гэмт хэрэгтэй тэмцэх албыг татан оролцуулах.

- 6.8 хувь нь дээрх бүгд гэсэн хариулыг өгсөн байна.

Судалгааны үр дүнд цахим залилан нь дан ганц тухайн улсын хил хязгаар дотор бус дэлхийн аль ч улсаас үйлдэгдэх боломжтой нь харагдav. Криптовалютын залилан, хуурамч онлайн худалдаа, романс залилан зэрэг аргууд нь дэлхийн ихэнх улс оронд нийтлэг үйлдэгдэг бөгөөд Монгол Улсад ч адилхан үйлдэгдэж байгаа нь онцлог ажиглагдсан. Монгол Улсад цахим залилангийн гэмт хэрэг нь сүүлийн жилүүдэд огцом нэмэгдэж байгаа бөгөөд нийт залилах гэмт хэргийн 33.2 хувь нь цахим орчинд үйлдэгдэж байна. Судалгааны үр дүнгээс харахад, цахим залилангийн эсрэг тэмцэхэд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, иргэдийн цахим боловсролыг нэмэгдүүлэх, хууль сахиулах байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх шаардлагатай.

Судалгааны үр дүнд, залилан мэхлэгчид үндэстэн дамнан өөр улсын нутаг дэвсгэрээс хил дамнасан үйл ажиллагаа явуулж байгаа нь тодорхой байна. Ийм нөхцөлд Монгол Улсын хууль сахиулах байгууллагууд хөрш орнуудын ижил төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагуудтай хамтран ажиллах, шаардлага гарч байна.

### Дүгнэлт

1. Цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн үйлдлийн аргуудад дүн шинжилгээ хийхэд өмнө болон одоогийн аргууд нь хувьсан өөрчлөгдөж, сэтгэл хөдлөл, хүсэл шуналыг урьдаач нөхцөл болгоод түүнд тааруулсан технологи шийдэл гаргах замаар улам нарийсаж байна. Тухайлбал, Фишинг, кардинг, романс залилан, крипто луйвар зэрэг арга нь хүний сэтгэл хөдлөлд үндсэн суурь нөхцөлөө тулгуур болгоод санхүүгийн схемчлэлээр дамжин технологийн шийдлийн замаар төрөл бүрийн платформ ашиглан хохирогчийн занганд оруулж байна. Мөн гүн хууралтын болон хуурамч хандивын сангийн аргыг нь судлахад гэмт хэрэгтнүүд хохирогчийн итгэл, өрөвдөх сэтгэл, цахим аюулгүй байдлын сул тал, мэдлэг хомс байдлыг хөшүүрэг болгон ашиглаж байна.



ХУУЛЬ САХИУЛАХАЙ

- Цахим орчинд үйлдэгдсэн залиах гэмт хэргийн үйлдлийн аргын дүн шинжилгээнд үндэслэн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны бодлого боловсруулж мэдээлэл солилцох, технологийн шийдэл гаргах, хууль эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх, иргэдийн боловсролыг нэмэгдүүлэх зэрэг чиглэл тус бүрээр төлөвлөлт гарган хэрэгжүүлэх.

- Бусад улс орны энэ салбарын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж манайд аюул занал гарахаас урьдчилан сэргийлж, гарах хохирлыг багасгах. (Жишээлбэл: Интерпол, олон улсын кибер аюулгүй байдлын байгууллагуудтай хамтран ажиллах)

- Цахим гэмт хэргийн үйлдлийн аргын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрийг урт богино хугацаанд үр өгөөжтэйгөөр системчлэн зохион байгуулах.

- Цахим гэмт хэргийн үйлдлийн аргад үндэслэн мөрдөн шалгах ажиллагааны хурдыг хангахын тулд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн холбогдох хэсэгт цахим мөрдөлт, цахим мэдүүлэг авах, цахим гүйлгээний хаалт, цахим эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөний хязгаарлалт зэрэг цаг, минутаар хэмжигдэх хурд шаардсан зохицуулалтыг иж бүрэн судалгаатайгаар багцлан зохицуулж, мөрдүүлэх.

- Дээрх саналтай уялдуулан банк, санхүүгийн багц хуулиудад нэмэлт оруулж банкны дансанд сэжигтэй гүйлгээ хийх, сэжигтэй гүйлгээг хязгаарласан, битүүмжилсэн үед харилцагчийн и-мэйл, гар утсаар мэдэгдэл очих, цахим тодруулга хийх, цахим хариу авах гэх мэт бодит шийдэл оруулах нь гэмт хэргийн гаралтыг бууруулах, иргэд хохирохос урьдчилан сэргийлэх боломжтой байна.

#### **Ашигласан материал**

- Цагдаагийн ерөнхий газар. (2023). Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны танилцуулга.
- BAE Systems Detica, & London Metropolitan University. (2014). *Organised crime in the digital age*.
- Михайлова, М. Ф. (2008). Гэмт хэргээ үйлдэх арга, түүний эрүүгийн эрх зүйн ач

холбогдол. Астрахань: Нэг сэдэвт бүтээл.

Карпов, Н. С., & Мозоль, А. П. (2003). *Гэмт хэргээ үйлдэх аргын тухай*. Олон улсын шинжлэх ухаан-практикийн бага хурлын материалууд. Уфа.

МУИС. (2013). *Дэлхийн эрүүгийн загвар хууль ба орчин үе* (х. 82). Улаанбаатар: МУИС.

Moore, T., Clayton, R., & Anderson, R. (2016). The economics of online crime. *Journal of Economic Perspectives*, 32(3), 3–4.

Google Scholar. (n.d.). Retrieved from <https://scholar.google.com>

Wiley Online Library. (n.d.). Retrieved from <https://onlinelibrary.wiley.com/doi/abs/10.1002/nem.2255>

Federal Bureau of Investigation. (n.d.). Romance scams. Retrieved from <https://www.fbi.gov/how-we-can-help-you/scams-and-safety/common-frauds-and-scams/romance-scams>

Investopedia. (n.d.). Nigerian scam. Retrieved from <https://www.investopedia.com/terms/n/nigerianscam.asp>

MoneySmart. (n.d.). Banking and credit scams. Retrieved from <https://moneysmart.gov.au/financial-scams/banking-and-credit-scams>

Norton. (n.d.). Clone phishing. Retrieved from <https://us.norton.com/blog/online-scams/clone-phishing#:~:text=Cybercriminals%20have%20many%20methods%20for,even%20create%20a%20fake%20website>

SEON. (n.d.). Job scam. Retrieved from <https://seon.io/resources/dictionary/job-scam/>

Cisco. (n.d.). What is phishing? Retrieved from <https://www.cisco.com/c/en/us/products/security/email-security/what-is-phishing.html#~ai-and-phishing>

Central Bank. (n.d.). How to avoid "you've won" scams. Retrieved from <https://www.centralbank.net/learning-center/security/targeted-scams/how-to-avoid-youve-won-scams/>



جامعة الملك عبد الله للعلوم والتقنية

- Australian Competition & Consumer Commission. (n.d.). Warning about fake charity scams. Retrieved from <https://www.accc.gov.au/media-release/warning-about-fake-charity-scams>
- Home Business Magazine. (n.d.). Ultimate guide: Business loan scams. Retrieved from <https://homebusinessmag.com/business-start-up/raising-money/ultimate-guide-business-loanscams/#:~:text=What%20Is%20a%20Business%20Loan%20Scam%3F%20Simply%20put%2C,obtain%20business%20and%20personal%20information%20in%20the%20process>
- HDFC ERGO. (n.d.). Online gaming frauds. Retrieved from <https://www.hdfcergo.com/blogs/cyber-insurance/online-gaming-frauds>
- Federal Bureau of Investigation. (n.d.). Sextortion scams. Retrieved from <https://www.fbi.gov/how-we-can-help-you/scams-and-safety/common-frauds-and-scams/sextortion>



## МӨРИЙТЭЙ ТОГЛООМ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН УЛАМЖЛАЛ, ХӨГЖИЛ

TRADITIONAL METHODS AND DEVELOPMENTS OF CRIMINAL LAWS ON GAMBLING

**T.Саруултөгс\***

Дотоод хэргийн их сургуулийн Гэмт явдал судлалын магистрант, цагдаагийн ахлах дэслэгч Pol. SR. Lt. Saruultugs T, MA Scholar in Criminology, University of Internal Affairs

\*Хариуцлагатай зохиогч: saruulleu0318@gmail.com

**Хураангуй:** Мөрийтэй тоглоомыг манай улс нь нийгмийн хор аюулын шинж, нийт гэмт хэргийн бүтцэд уг гэмт хэргийн эзлэх хувь, эрх зүйн орчны шинэчлэл, шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх туршлага, эрүүгийн эрх зүйн бодлого зэргээс хамааран үе үеийн эрүүгийн хуулиар зохицуулж, гэмт хэрэгт тооцож иржээ.

Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн эрх зүйн орчны өөрчлөлтийг тус гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудалд нийцүүлэн хийснээр уг гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох ажиллагаанд үр дүн гарах ач холбогдолтой учир энэ төрлийн судалгааны хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн үе үеийн эрх зүйн зохицуулалтын өөрчлөлтийг одоогийн эрүүгийн хуультай харьцуулан судлах аргаар гүйцэтгэж, мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын өөрчлөлтийг гэмт явдлын үйлдлийн арга, шалтгаан нөхцөлд тохирсон байдлаар тодорхойлохыг зорилоо.

Олон улсын мөрийтэй тоглоомын хууль эрх зүйн ангилалд манай улсын мөрийтэй тоглоомыг хуульчилж ирсэн түүхэн хөгжлийг уялдуулан дүгнэж, цаашдын чиг хандлагыг тодорхойлж санал, дүгнэлт гаргасан нь энэхүү судалгааны ажлын шинэлэг тал болсон.

**Abstract:** Gambling has been considered a crime in our country by successive criminal laws depending on its social danger, the proportion of this crime in the total criminal structure, legal environment reforms, experience in combating new types of crimes, and criminal law policies. The need for this type of research arises because changes in the legal environment of gambling crimes in accordance with the problems faced in combating this crime are important for the detection and suppression of this crime.

Within the framework of this research, changes in the legal regulation of gambling crimes over time were studied by comparing them with the current criminal law. The purpose of the research is to determine the changes in the legal regulation of gambling crimes in accordance with the methods and causes of the crime.

The innovative aspect of the research is that it summarizes the historical development of our country's legalization of gambling in the international gambling legal classification, identifies future trends, and makes suggestions and conclusions.

**Түлхүүр үгс:** Мөрийтэй тоглоом зохион байгуулах, цахим мөрийтэй тоглоом, казино, эрүүгийн хууль, шүүх цаазын бичиг.

**Keywords:** Organized gambling, electronic gambling, casinos, criminal law, writs of execution.

### Үндэслэл

Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг нь олон улсын түвшинд болон Монгол улсад нийгмийн хор

аюул өндөр гэмт хэрэгт тооцогдож байх бөгөөд мэдээллийн технологи, цахим орчны хурдацтай хөгжлийг дагаад энэ төрлийн гэмт хэргийн үйлдлийн арга,



МОНГОЛ УЛСЫН  
ДАВЧИНЫ СИСТЕМЫ  
МОНГОЛЫН  
ДАВЧИНЫ СИСТЕМЫ

хэрэгсэл улам боловсронгуй болон хөгжиж, сүүлийн жилүүдэд цахим хэрэгсэл ашиглан мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн гаралт тогтмол өсөн, түүнтэй зэрэгцэн хууль бусаар олсон орлогоо нуун далдлах зорилгоор мөнгө угаах, татвар төлөхөөс зайлсхийх зэрэг гэмт хэргийн гаралт мөн нэмэгдэж байна.

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас цөөнгүй хүмүүс эд хөрөнгөөрөө хохирч, цаашлаад амь насаа алдахад хүргэж байгаагаас үзэхэд мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх хэрэгцээ, шаардлага нэгэнт үссэн байна.

Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын уламжлал, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж буй үйл ажиллагаа, түүнтэй холбоотой үүсэж буй нийгмийн харилцаа нь энэхүү судалгааны ажлын объект болно.

Судалгааны ажлын арга зүйн үндэс нь танин мэдэхүйн диалектикийн арга бөгөөд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулах, индуц, дедуц, таамаглал дэвшүүлэх зэрэг ерөнхий арга зүйг ашигласнаас гадна онол, арга зүйн тулгуур ойлголт, гол үзэл санаа, судалгааны үр дүнг нээн гаргахдаа баримт бичиг, хууль тогтоомж, эх сурвалжид дүн шинжилгээ хийх, эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн эх сурвалжийг харьцуулан судлах аргыг ашиглан, шинжлэх ухааны үндэслэл бүхий дүгнэлт хийсэн болно.

Судалгааны хүрээг мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийг Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилж ирсэн байдлаар хязгаарласан бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжлийг өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан судлах замаар эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чиглэсэн санал, зөвлөмж боловсруулахыг зорьсон.

### Үндсэн хэсэг

Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн талаарх олон улсын эрх зүйн зохицуулалтыг судалж үзэхэд

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Европын бүс нутаг хариуцсан салбар байгууллага болох Монниволоос 2013 онд явуулсан судалгаагаар дэлхийн улс орнуудыг З төрөлд хуваан авч үзсэн байна ((СМА), 2022). Үүнд:

1. Цахим мөрийтэй тоглоомыг хүлээн зөвшөөрч, хуулиар зохицуулдаг улс орнууд (цааган);

2. Цахим мөрийтэй тоглоомыг хууль бус биш гэж үздэг боловч хууль, эрх зүйн хүрээнд зохицуулдаггүй улс орнууд (саарал);

3. Цахим мөрийтэй тоглоомыг хууль бус гэж үздэг улс орнуудыг (хар) ангилалд оруулан З хувааж үзсэн байна.

Эндээс саарал болон хар ангиллын улс орнууд нь цахим мөрийтэй тоглоомыг хууль, эрх зүйн хүрээнд зохицуулдаггүй гэж ойлгож болохоор байна. Өөрөөр хэлбэл, эдгээр жагсаалтад багтсан улсууд мөрийтэй тоглоом, казиногийн тусгайлсан хуульгүй болж таарч байна. Харин цагаан ангилалд хамаарах улсууд нь мөрийтэй тоглоомыг тусгайлсан хуулиар зохицуулсан байх бөгөөд тэдгээр улс орнууд нь энэ чиглэлийн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлснээр мөрийтэй тоглоомоор дамжуулж мөнгө угаах эрсдэл буурдаг гэж үздэг байна.

Харин манай улс Монниволын судалгааны гарын авлагад дурдагдсан аль ангилалд багтдаг болохыг тодорхойлохын тулд мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийг үе үеийн эрүүгийн хуульд хуульчилж ирсэн түүхэн уламжлал, тухайн хуулиудын эрх зүйн зохицуулалтын ялгаатай болон төсөөтэй шинжийг тодорхойлох нь зүйтэй юм.

Мөрийтэй тоглоом зохион байгуулах, мөрийтэй тоглох үйлдлийг манай улс анх 1926 оноос хойш буюу БНМАУ-ын Эрүүгийн хуульд мөрийтэй тоглох үйлдлийг гэмт хэрэгт тооцсон байна (С. Санчиржав, 2015). Үүнээс хойш БНМАУ-ын 1929, 1934 онуудын “Шүүх цаазын бичиг”, БНМАУ-ын 1942, 1961, 1986 онуудын “Эрүүгийн хууль”, 2002, 2015 оны Монгол Улсын Эрүүгийн хуулиудад мөрийтэй тоглох, мөрийтэй тоглоом зохион



МОНГОЛ УСГЫН ХУУЛЬ САХИУЛАХАЙ

байгуулах үйлдлийг гэмт хэрэгт тооцож иржээ.

Тодруулбал, БНМАУ-ын 1926 оны “Шүүх цаазын бичиг”-ийн 131-р зүйлд “...Даалуу хөзөр зэргээр мөрийцөн наадагсдын мөрийцсөн юм зүйлийг албадан хурааж..., 132-р зүйлд “...Аливаа хүн ашгийг хичээж гэр орон бэлтгэж бусдыг мөрийцөн наадуулах... (Д.Адъяабазар, 1998)” үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилж байжээ. Энэ нь өнөөгийн эрүүгийн хуулийн зарим зүйл ангид заасан орон байр бэлтгэсэн болон хууль бусаар олсон орлогыг хураах шинжийг агуулж байгаагаараа онцлог байна.

Үүний дараа БНМАУ-ын 1929 оны “Шүүх цаазын бичиг”-д өмнөх хуулийн агуулгыг бүрэн тусгаж, мөрийтэй тоглосон бол хорихгүйгээр албадан ажил хийлгэх ялыг нэмж оруулж өгсөн нь өнөөгийн эрүүгийн хуульд заасан нийтэд тустай ажил хийлгэх ялыг тус гэмт хэрэгт хэрэглэсэн анхны тохиолдол болжээ.

БНМАУ-ын 1934 оны “Шүүх цаазын бичиг” хуульд мөрийтэй тоглоомыг” Засаг захиргааны журмыг зөрчих онц аюултай гэмт хэрэг” бүлэгт багтаан “...Аливаа хүмүүс мөрийцөн наадах орон савыг зориуд нээн гаргасан, тэрчлэн аж амьдралаа болгон мөрийцөн наадсан бол... (АИХ, Шүүх цаазын бичиг, 1934)” гэж заасан нь одоогийн эрүүгийн хуульд зарим төрлийн гэмт хэргүүдэд хүндрүүлэх шинжээр хэрэглэгддэг “амьдралын эх үүсвэрээ болгосон” гэх нэр томьёог тусгайлан оруулжээ. Энэхүү хууль хэрэглээ нь ард иргэдийг мөрийтэй тоглоомд донтох, амьдралаа алдах зэргээс урьдчилан сэргийлэх агуулгыг шингээсэн эрх зүйн зохицуулалт болсон байна.

БНМАУ-ын 1942 оны Эрүүгийн хуулийн 121-р зүйлд “...Мөрийтэй тоглоомыг үйлдэхэд зориулсан байрыг нээн байгуулж ажиллуулах ба түүнчлэн мөрийтэй тоглоомыг дагнан эрхлэх буюу удаа дараагаар тоглосон байвал 5 жил хүртэл хугацаагаар хорьж... (АИХ, Эрүүгийн хууль, 1942)” шийтгэнэ хэмээжээ. Энэ үед мөрийтэй тоглох, мөрийтэй тоглоом зохион байгуулах

үйлдлийг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр эрүүгийн хуульд зохицуулсан бөгөөд анх удаа мөрийтэй тоглосон бол хөнгөрүүлж, харин мөрийтэй тоглох орон байрыг нээсэн, ажиллууласан, мөрийтэй тоглоомыг дагнан эрхлэх, удаа дараа тоглосон тохиолдолд хүндрүүлэх бүрэлдэхүүнд хамааруулан үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэж байжээ.

БНМАУ-ын 1961 оны Эрүүгийн хуульд “...Мөрийтэй тоглоомыг тусгайлан бэлтгэлгүйгээр өөрийн мэдлийн орон байранд тоглуулсан...” бол хөнгөрүүлж, “...Мөрийтэй тоглоом тоглоход зориулан байр бэлтгэн ажиллууласан... (АИХ, Эрүүгийн хууль, 1961)” бол өмнөх хуулийн нэгэн адил хүндрүүлэн үзэж байсан байна.

БНМАУ-ын 1986 оны Эрүүгийн хуулийн 234 дүгээр зүйлд “...Төрийн зохих байгууллагаас зөвшөөрөгдөөгүй мөрийтэй тоглоом тоглосон, зохион байгуулсан...” (АИХ, Монгол Улсын Эрүүгийн хууль, 1986) гэж хуульчилсан нь тухайн үеийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд зарим төрлийн мөрийтэй тоглоомын үйл ажиллагааг зөвшөөрч байжээ гэж үзэж болох юм. Үүнтэй холбоотой нэгэн жишээг дурдахад манай улсын хууль тогтоох байгууллагаас 1998 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр “Казино”-гийн тухай хуулийг баталж, уг хуулийн дагуу казино байгуулах эрхийн тендер зарлагдаж “Мон Макао” компани шалгарч байсан боловч тендерийн сонгон шалгаруулалтын шударга бус байдлаас шалтгаалан Улсын их хурлаас 1999 оны 01 сарын 22-ны өдөр Казиногийн хуулийг хүчингүй болгож байжээ. Үүнтэй холбоотойгоор казиногийн хуулийг анх санаачилсан нэр бүхий Улсын Их Хурлын 3 гишүүн болон тендерт шалгарсан хуулийн этгээдийн захирал нарын 4 хүн авлигын хэрэгээр эрүүгийн хариуцлага хүлээж байсан байна (<https://mn.wikipedia.org>, 1999). Мөн дээрх үйл явдлаас улбаалан Улсын Их Хурлаас казино, мөрийтэй тоглоом нь улс орны эдийн засаг, хүн амын амьжиргааны нөхцөл зэрэгтэй төдийлөн тохиорхгүй явдал юмаа гэж үзэж 1999 оны 01 сарын 22-ны өдөр “Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай” бие даасан хуулийг баталснаар казиногийн төрлийн

үйл ажиллагааг нэг мөр хориглож, өнөөг хүртэл хүчин төгөлдөр хэвээр үйлчилж байна.

Тухайн цаг хугацаанд казино буюу мөрийтэй тоглоомыг манай улс нь хүлээн зөвшөөрч, тусгайлсан хуулиар зохицуулж байсан нь одоогийн Монголын ангиллын цагаан жагсаалтын улс орон байсан түүхэн жишээ юм. Үүнээс хойш мөрийтэй тоглоомыг тусгайлсан казиногийн хуулиар зохицуулах оролдлого одоог хүртэл хэд хэдэн удаа хууль тогтоох байгууллагын хэмжээнд өrnөсөн боловч төдийлөн үр дүнд хүрээгүй хэвээр байна. Энэ нь манай улсын эдийн засаг, хүн амын боловсрол, казиногийн нийгэмд үзүүлэх хор уршиг, эрүүгийн эрх зүйн бодлого болон бусад шалтгаанаас болсон байж болох талтай юм.

2002 онд батлагдан хэрэгжиж байсан Эрүүгийн хуулийн 243 дугаар зүйлд “Хуулиар хориглосон мөрийтэй тоглоом /казино/ тоглосон, түүнийг зохион байгуулсан...” бол хөнгөрүүлж, харин “...давтан үйлдсэн... (УИХ, Эрүүгийн хууль, 2002)” тохиолдолд хүндруүлэн үзэж, үе үеийн өмнөх хуулиудын нэгэн адил мөрийтэй тоглох, мөрийтэй тоглоом зохион байгуулсан үйлдлийг гэмт хэрэг хэмээн үзэж байжээ.

Харин манай улс нь мөрийтэй тоглоом тоглох, зохион байгуулах явдлыг 2015-2020 оны хооронд эрүүгийн хуулиас хасаж гэмт хэрэг биш хэмээн үзэж, зөрчлийн тухай хуулиар зохицуулж байсан. Өөрөөр хэлбэл, тухайн цаг хугацаанд манай улс нь мөрийтэй тоглоомыг хууль бус гэж үздэггүй боловч тусгайлсан мөрийтэй тоглоомын тухай хууль гаргаж зохицуулдаггүй улс буюу ФАТФ-ын салбар байгууллага болох Монголын гарын авлагад дурдсанаар саарал ангиллын улс байсан гэж үзэж болох юм.

Хууль тогтоох дээд байгууллагаас 2015 онд батлагдан 2017 оноос хүчин төгөлдөр хэрэгжиж буй Монгол Улсын Эрүүгийн хуульд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж, мөрийтэй тоглоом зохион байгуулах явдлыг хөнгөрүүлэх болон хүндруүлэх бүрэлдэхүүнтэйгээр эрүүгийн хуулийн 20 дугаар бүлэг (Олон нийтийн аюулгүй

байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг)-т багтаан хуульчилжээ.

Тус нэмэлт өөрчлөлтөөр мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний шинжид “Олон нийтийн газар, эсхүл мэдээллийн технологи ашиглан ашиг олох зорилгоор шоо, хөзөр, бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом зохион байгуулсан”, хүндруүлэх бүрэлдэхүүний шинжид “Үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог хуулиар хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулсан, эсхүл ажиллуулсан” бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зохицуулжээ. Харин өмнөх үе үеийн хуулиудад гэмт хэрэг хэмээн үзэж байсан мөрийтэй тоглох үйлдлийг зөрчилд тооцож, зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байна.

Мөн мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийг “Мэдээллийн технологи ашиглан” үйлдэж болох үйлдлийн аргыг нэмэлтээр оруулж, цахим мөрийтэй тоглоом зохион байгуулсан үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндсийг анх удаа бүрдүүлж өгчээ.

Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн үндсэн болон хүндруүлэх бүрэлдэхүүний шинжийг эрдэмтэн, судлаачдын бүтээлд тайлбарласнаар авч үзвэл, “Мөрийтэй тоглоом зохион байгуулсан” гэж хүн ам олноор цуглардаг үзвэр, үйлчилгээний нийтийн зориулалттай газар, эсхүл мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим сүлжээг ашиглан ашиг хонжоо олох зорилгоор шоо, хөзөр, тэдгээрт зориулсан тоглоомын тусгай ширээ, электрон хэрэгсэл зэрэг мөрийтэй тоглох зориулалтаар өрөө, тасалгаа, тоног төхөөрөмжийг ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог тоглоомын хууль бус орчныг бүрдүүлсэн байхыг хэлнэ (Б.Галдаа, 2021) гэж өөрийн бүтээлдээ дурджаа.

Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн хүндруүлэх бүрэлдэхүүн нь хуулиар хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулсан, ажиллуулсан шинжийг агуулдаг. Тэгвэл



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛИАРЫН  
ХАРИУЦЛАГА  
ХҮЛЭЭЛГЭХЭЭР  
ХУУЛЬЧИЛСАН  
БАЙНА



МОНГОЛ УЛСЫН ХАРЧИАЛЫН ТАРХАНЫ СОХИОН БАЙГУУЛАХААС ХҮЧИРГЭЛЭГДСЭН ТӨГЛООМЫН ГАЗРЫГ ХЭЛНЭ

манай улсад “хуулиар хориглосон мөрийтэй тоглоом” гэдгийг нарийвчлан тодорхойлох нь зүйтэй. Монгол Улсын Их Хурлаас 1999 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр баталсан “Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай” хуулийн 1 дүгээр зүйлд “Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт казино байгуулах, ажиллуулахыг хориглоно” (УИХ, 1999) гэж заасан байдаг. Иймд Монгол Улсын хуулиар хориглосон мөрийтэй тоглоом бол казино юм гэж тодорхойлж болохоор харагдаж байна.

Харин “Казино” гэдгийг үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршсан тоглоом тоглуулдаг зориулалтын өрөө, тасалгаа, танхим бүхий мөрийтэй тоглоомын газрыг хэлнэ. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр казино байгуулсан, ажиллуулсан тохиолдолд Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байна. Казино тоглуулах, түүнийг зохион байгуулах зорилгоор хууль бусаар слот машин (мөнгө, түүнийг орлогч токенс хэрэглэж тоглодог электрон хэрэгсэл), слот машин тоглуулахад хэрэглэдэг мөнгө орлогч металл, чип (хуванцар зоос) казиногийн ширээ, бусад тоног төхөөрөмж хийх, олж авах нь түүнийг зохион байгуулсан гэдэгт хамаарна (Б.Галдаа, “Эрүүгийн эрх зүй” /срөнхий, тусгай анги/, 2021) гэж хурандаа Б.Галдаа өөрийн бүтээлдээ бичжээ. Өөрөөр хэлбэл манай улс нь казиног эрүүгийн хуульдаа шууд гэмт хэрэг хэмээн заагаагүй боловч хуулиар хориглосон мөрийтэй тоглоом гэж төлөөлүүлэн хуульчилжээ гэж үзэж болохоор байна.

Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн субъектив талын шинжид мэдээллийн технологийн хэрэгсэл ашиглан ашиг олох зорилготой, шунахайн сэдэлтэй үйлдлийн аргыг нэмэлтээр оруулж өгсөн явдал нь цаг үеэ олсон зохицуулалтын хэлбэр болсныг эрүүгийн хэргийн шүүхээр шийтгэгдсэн шүүхийн практикуудаас харж болох юм.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2020 оноос одоог хүртэлх хугацаанд мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргээр нийт 275 гэмт хэрэг эцэслэн шийдвэрлэгдэж, 97 хувь нь хөнгөрүүлэх бүрэлдэхүүний шинжээр, 3 орчим хувийг хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжээр эцэслэн шийдвэрлэсэн тоон үзүүлэлт гарч байна<sup>1</sup>.

Эрүүгийн хэргийн шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргүүдийн дийлэнх хувийг мэдээллийн технологийн хэрэгсэл ашиглан үйлдэгдсэн гэмт хэргүүд эзэлж байна. Энэ нь хэрэгцээ шаардлагаа оновчтой зөв тодорхойлж эрх зүйн орчныг бүрдүүлж өгсний үр дүн болжээ гэж дүгнэж болох талтай юм. Гэтэл нөгөө талдаа энэ төрлийн гэмт хэрэг нь манай улсын хүн амын дунд ихээхэн тархсан, хувь хүний болоод улс орны эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг үр дагаврыг үүсгэх гэмт явдал болсныг харуулж байна.

Түүврийн болон харьцуулан судлах судалгааны аргаар Эрүүгийн цагдаагийн алба болон дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдэд мөрдөн шалгах ажиллагаанд шалгагдаж байгаа мөрийтэй тоглоом зохион байгуулах 15 хэргийн материалтай уншиж танилцан гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох чиглэлээр судалгаа хийж ажилласан. Судалгаанд ашиглагдсан мөрийтэй тоглоомын хэргүүдэд дунджаар 1 цахим мөрийтэй тоглоомын хэрэгт 3-5 иргэний арилжааны банкны дансыг ашиглан цэнэглэлт, тараалтыг хийж, тэдгээр иргэд нь мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд өөрийн нэр дээрх бүртгэлтэй арилжааны банкны дансыг бусдад ашиглуулсан нөхцөл байдал тогтоогдож, 80 орчим хувь нь бусдад тодорхой хэмжээний үнийн дунгээр дансаа худалдсан байна.

Тэдгээр хүмүүсээс дансаа ашиглуулсан хүнийг таньж мэдэх үү гэх асуултад 100 хувь “танихгүй” гэж хариулсан байв. Мөн түүнчлэн арилжааны банкны дансаа бусдад ашиглуулсан гэх

<sup>1</sup> Монгол Улсын шүүхийн шийдвэрүүдэд хийсэн шинжилгээ.



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛИАР ХӨРӨГЛӨҮҮС СҮРҮҮЛЭЛТ

хүмүүс нь тэнэмэл байдлаар амьдардаг, архины хамааралтай, боловсролын түвшин доогуур, өндөр наасны зэрэг хүмүүс цөөнгүй хувийг эзэлж байгаа нь гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүд нь эдгээр хүмүүсийн эмзэг байдлыг ашиглан гэмт хэргээ үйлдэх арга хэрэгсэл болгон ашиглаж байна гэж үзэж болох ч нөгөө талдаа гэмт хэрэгт хамтран оролцож, хууль бус үйлдэл гэдгийг мэдсээр байж ашиг хонжоо олох зорилготой байж ч болох юм. Манай улсын Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт хамтран оролцож, бусдад дансаа ашиглуулж, хууль бус мөнгөнөөс шан харамж авдаг зохион байгуулалттай гэмт бүлэгт хамаарах хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа хэдий ч ашиг хонжоо олох зорилгоор бусдад арилжааны банкны дансаа худалдсан хүмүүсийн үйлдэлд эрүүгийн болон зөрчлийн тухай хуулиар ямар нэгэн хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин бүрдээгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг нуугдмал, далд хэлбэрээр үйлдэгдэх шалтгаан нөхцөл болсоор байна.

Мөн цахим мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэгт ашиг хонжоо олох, өөртөө болон бусдад давуу байдал үүсгэх зорилгоор эрхэлж буй ажил, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж гэмт хэрэгт хамтран оролцсон, гэмт хэргийг зохион байгуулсан явдал байдаг. Тухайлбал, төрийн болон хувийн хэвшилийн тэр дундаа, хууль хяналт, банк санхүү, иргэний бүртгэлийн байгууллагын албан тушаалтнууд мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэгт холбогдож, мөрийтэй тоглоом зохион байгуулсан, мөнгө угаасан үйлдэлдээ эрүүгийн хариуцлага хүлээсээр байна. Энэ төрлийн эрх зүйн зохицуулалтын олон улсын туршлагаас нэгэн жишээг авч үзэхэд ОХУ-ын эрүүгийн хуулийн 171.2 дугаар зүйл “Мөрийтэй тоглоом хууль бусаар зохион байгуулах, тоглуулах” зүйл заалтад “...албан тушаалын байдлаа ашиглаж эсхүл онц их хэмжээний орлого олж үйлдсэн...” (Ж.Эрдэнэбулган, 2021) бол гэж тусгайлан хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжид оруулан хуульчилж өгсөн зохицуулалт байна.

Манай улс нь мөрийтэй тоглоомыг тусгайлсан хуулиар хориглож, Эрүүгийн хуульдаа гэмт хэрэгт тооцсон улс орны хувьд мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчны өөрчлөлтийг гэмт хэрэг үйлдэж буй арга, хэлбэр, гэмт явдлын шалтгаан нөхцөлд тохишуулан боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага үүссээр байгааг дээрх жишигээнүүдээс харж болох юм.

### Дүгнэлт

Монгол улс нь 1926 оны “Шүүх цаазын бичиг” хуульдаа даалуу, хөзөр зэргээр мөрийцөн наадах, наадуулах явдлыг гэмт хэрэг хэмээн хуульчилсан явдал нь мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн анхны эрх зүйн зохицуулалт болсон байна. Үүнээс өмнөх үед мөрийтэй тоглох, мөрийтэй тоглоом зохион байгуулах явдал нь хүн амын дунд төдийлөн дэлгэрээгүй, аль эсвэл нийгмийн аюулын хэмжээ нь гэмт хэргийн шинжид багтахааргүй байсан байж ч болох юм. Мөрийтэй тоглоомын анхны эрх зүйн зохицуулалтаас хойш манай улс нь нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүний болоод технологийн дэвшилийн хөгжил, гэмт явдлын гаралт, шалтгаан нөхцөлтэй уялдуулан мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийг үе үеийн эрүүгийн хуулиудад өөрчлөн зохицуулж иржээ.

Мөрийтэй тоглоом зохион байгуулах явдал нь өнөө үед цахим мэдээллийн технологи ашиглан үйлдэгдэж, нийгмийн аюулын шинж болох хууль бус мөнгөний урсгал нь хүний наймаа, хууль бус галт зэвсгийн худалдаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт зэрэг гэмт хэргийн нэгэн адил дэлхийн ихэнх улс орны анхааралд байх болсон. Үүнтэй холбоотойгоор манай улс 2020 онд мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн шинжид мэдээллийн технологи ашиглан үйлдэгдэх аргыг хуульчилж өгсөн нь цахим мөрийтэй тоглоомын гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн явдал болжээ. Гэсэн хэдий ч мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийг үйлдэгч нар нь бүлэг зохион байгуулалтад орж, нууц далд аргаар үйлдэгдэх боломжийг улам бүр



МОНГОЛ УЛСЫН ТӨГЛӨОМ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ҮЙЛДСЭН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ БИЙ БОЛГООД БАЙНА.

эрэлхийлж, ашиг хонжоо олохын тулд албан тушаалын байдлаа урвуулан ашиглах явдал хүргэл гарах болсон нь эрүүгийн хуульд зохих нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг бий болгоод байна.

Мөрийтэй тоглоомыг гэмт хэрэгт тооцох эсэх нь тухайн улс орны гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын асуудал мөн бөгөөд, одоогийн байдлаар дэлхийн улс орнууд мөрийтэй тоглоомтой холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлсэн байдлаараа “хүлээн зөвшөөрсөн”, “хагас зөвшөөрсөн”, “огт зөвшөөрдөггүй” гэсэн 3 ангилалд хуваагдаж байна. Монгол Улсын хувьд дээрх ангиллын “огт зөвшөөрдөггүй” ангилалд хамаарч байна.

Өнөө үед дэлхий нийтэд мөрийтэй тоглоомыг хүлээн зөвшөөрч тусгайлсан хуулиар зохицуулах хандлага бий болж байгаатай холбоотойгоор манай улсын хувьд ч казиногийн тухай хуулийн төслийг хууль тогтоох байгууллагаас удаа дараа санаачлах явдал гарч байна. Энэ тохиолдолд казиногийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг зөв бүрдүүлэх, олон улсын сайн туршлагыг судлах, мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийг үүссэн шинэ нөхцөл байдалд тохируулан хуульчлах шаардлагатай юм.

### Санал

1. Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний шинжид ашиг олох зорилгоор бусдад дансаа ашиглуулсан үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нэмэлт өөрчлөлтийг оруулах.

2. Албан тушаалын байдлаа ашиглан мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийг үйлдсэн, хамтран оролцсон тохиолдолд хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжээр эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр нэмэлт өөрчлөлтийг оруулах.

3. Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийг удаа дараа үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжээр эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр нэмэлт өөрчлөлтийг оруулах.

4. Мөрийтэй тоглоомын тусгайлсан хууль батлагдсан тохиолдолд Эрүүгийн хуульд мөрийтэй тоглоом хууль бусаар зохион байгуулах гэмт хэргийг бусад хуульд уялдуулан зохицуулалт хийх.

### Ашигласан материал

Монгол Улсын Их Хурал. (2002, 2017).

*Монгол Улсын Эрүүгийн хууль.*  
Улаанбаатар.

Монгол Улсын Их Хурал. (1999). *Казино байгуулах, ажилтуулахыг хориглох тухай* хууль. Улаанбаатар.

Монгол Улсын Их Хурал. (2019, 9-р сар 17). *Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.*  
Улаанбаатар.

Галдаа, Б. (2021). *Эрүүгийн эрх зүй* (Ерөнхий, тусгай анги). Улаанбаатар.

Эрдэнэбулган, Ж., Уянга, М., Золбоо, Т., Батбаяр, Б., & Тамир, Б. (2021). *Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль* (167-р тал). Улаанбаатар.

Энххүслэн, О. (2022). *Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлд заасан мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн зүйлчлэл, нөхцөл байдал, түүнд хамаарах асуудал.* Улаанбаатар.

Санчиржав, С. (2015). *Мөрийтэй тоглох гэмт хэргийн эрүүгийн хариуцлагын зарим асуудал* (6-10-р тал). Улаанбаатар.

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан. (n.d.). Retrieved from <https://www.shuukh.mn/>

Монголбанк. (2022). *Санхүүгийн мэдээллийн албаны типологийн тайлан.*  
Улаанбаатар.

# ОРГОН ЗАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

## THE ANALYSIS ON THE FACTORS AND CAUSES LEADING TO THE CRIME OF ESCAPING FROM CUSTODY



УЧИЛГААНЫ САЛБАРЫН  
ХААНДЫН АДЫГАА

**Ч.Батболд\***

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн тэнхимийн ахлах багш, доктор, дэд хурандаа  
Lt. Col. Batbold Ch, Ph.D, Senior Lecturer, Department of Court Decision Executive Management and Strategy, Academy of Management, University of Internal Affairs

\*Хариуцлагатай зохиогч:chbatbold8@gmail.com

**Хураангуй:** Хорих байгууллага нь хорих ял эдэлж буй хоригдол, цагдан хоригдож буй хоригдогсдын зүгээс гэмт хэрэг үйлдэх, нийгэм, иргэдийг гэмт халдлагад өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага юм.

Улс орны нийгэм, эдийн засгийн байдал, хорих байгууллагын орчин, нөхцөл зэрэг цөөнгүй шалтгааны улмаас хорих байгууллагын аюулгүй байдалд халдах, оргон зайлах гэмт явдал гарсаар байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэн тэргүүнд анхаарах нэг чиглэл нь оргон зайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил байсаар ирсэн.

Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги болон цагдан хорих байранд 2020-2024 оны хооронд үйлдэгдсэн оргон зайлах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг баримт бичигт дүн шинжилгээ хийх болон ярилцлагын аргыг ашиглан судлан үзлээ.

Энэхүү өгүүллээр Монгол Улсын эрүүгийн ял шийтгэлийн нэг үндсэн чиглэл болох хорих ял эдлүүлэх ажиллагааг хуульд заасан хүрээнд хэрэгжүүлэх, ялын гарцаагүй байх зарчмыг хангахад ноцтой хор аюул үүсгэдэг оргон зайлах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлан урьдчилан сэргийлэх арга замыг тодруулахыг зорьсон болно.

**Abstract:** A prison is a government entity with specific functions that protect society and aim to prevent the commission of crimes by prisoners serving sentences in custody. It also safeguards citizens from criminal attacks.

Despite this, issues such as the social and economic situation of the country, along with the environmental conditions within prisons, contribute to crimes related to breaches of prison security including escapes. Consequently, a priority of the execution of judicial decisions has focused on preventing the crime of escaping from custody.

This article examines the causes and conditions of escape crimes that occurred in prisons and detention centers managed by the General Department of Court Enforcement from 2020 to 2024. It employs document analysis and interview methods for the research. One of its primary objectives is to investigate the causes and conditions leading to escape from custody crimes, which pose a serious threat to the enforcement of prison sentences as defined by law and the principle of certainty in punishment.

**Түлхүүр үсэ:** Хорих ял, оргон зайлах, пенитенциар гэмт явдал, шалтгаан, нөхцөл.

**Key words:** Imprisonment, to escape from custody (<https://www.gotocourt.com.au>, 2024), penitentiary crime, causes and conditions.





МОНГОЛ УУДААНЫ ХАГААНЫ ААНЫ САХИУЛАХАЙ

## Үдиртгал

Дэлхийн ихэнх улсад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тохирох ял шийтгэлийг хүлээлгэн, тухайн этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн ялын гүйцэтгэлийн олон талт арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Монгол Улс ч энэхүү чиг хандлагыг баримтлан эрүүгийн хариуцлагын зорилгыг гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх болон гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх явдал хэмээн эрх зүйн зохицуулалтын хүрээнд ялын гүйцэтгэлийн бодлогыг шинэчлэн тодорхойлжээ.

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь ялын бодлого, зорилгыг хангахад чиглэх ба ялын бодлого нь тухайн улс орны хөгжлийн үе шат дахь нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүйн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журмыг хангах, хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэг хэрэгжүүлэхэд төрөөс баримталж буй чиглэл бөгөөд төр эрүүгийн ялын бодлогоо хариуцлагын оновчтой төрөл, тогтолцоог бий болгох, оногдуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох, түүгээр дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зэрэг арга хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлдэг (Батболд, 2023).

Хорих ял эдлүүлэх ажиллагааны 2020-2024 оны 5 жилийн тайлан (Хорих ял эдлүүлэх алба, тайлан, 2020-2024) мэдээнд дүн шинжилгээ хийж үзвэл, нийт 16 гэмт хэрэг гарсан ба үүнээс, хүний биед гэмтэл учруулсан 3 буюу 18.75 хувь, хууль сахиулагчийг эсэргүүцэх 1 буюу 6.25 хувь, оргон зайлзах 12 буюу 75 хувь байгаа нь энэхүү гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг зайлшгүй судлах шаардлага үүссэн гэж үзэн оргон зайлзах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхтэй холбоотой дүгнэлт-саналыг судалгааны үндсэн дээр дэвшигүүлэхийг зорилоо.

### Үндсэн хэсэг

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олон нийтээс тусгаарлаж, тодорхой хугацаагаар хязгаарлагдмал орчинд албадлагаар

хорьдог өөрөөр хэлбэл, гэмт хэрэгтний оршин амьдрах нийгмийн бичил орчин болдог талаар эрдэмтэн судлаачдын бүтээлд тодорхой дурдсан байдал билээ.

Энэхүү орчинд үйлдэгддэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл нь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой бөгөөд уг асуудлыг криминологийн шинжлэх ухааны нэг салбар болох “Пенитенциар гэмт явдал судалд” судалдаг.

Би энэ удаагийн илтгэлийг зорчих эрхийг хязгаарлах ял болон баривчлах шийтгэлээс оргох тухай биш зөвхөн хорих ял эдлүүлэх ажиллагаанаас оргон зайлзах асуудлын хүрээнд судалсан болно.

Хорих байгууллагаас оргон зайлзах гэдэг нь хорих анги, цагдан хорих байрны амьдралын болон үйлдвэрийн бүсээс харуул хамгаалалтын албан хаагчийн сонор сээрэмжгүй байдлыг ашиглан, харуул хамгаалалтын техник, тоног төхөөрөмжийг эвдэж сүйтгэх, алба хаагчийн амь бие, эрүүл мэндэд хүч хэрэглэн халдан довтлох зэрэг аргаар хорих ял эдлэхээс зайлсхийх санаа бодлоо гүйцэтгэж байгааг ойлгоно. Өөрөөр хэлбэл, хорих ял эдлүүлэх ажиллагаанаас санаатайгаар зайлсхийх үйлдлийг оргон зайлзах гэж тодорхойлж болох юм.

Хорих ял эдлүүлэх ажиллагаанаас оргон зайлзах гэмт хэргийг эрүүгийн эрх зүйн үүднээс авч үзвэл, уг гэмт хэрэг нь шууд санаатай буюу урдаас нарийн төлөвлөгдж үйлддэг бөгөөд хоригдол нь гэмт хэрэг үйлдэх субъектив санаа бодол төрсний дараа өөрийнхөө оргох үйлдлийг ганцаар болон хамтаар үйлдэх боломжийг эрэлхийлж төлөвлөж, бэлтгэдгээрээ онцлогтой.

Үүнээс гадна объектив талын хувьд нууц далд аргаар үйлдэгддэг ба ямар нэгэн багаж, зэвсгийн чанартай эд зүйл ашиглаж хорих байгууллагын хамгаалалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслийг эвдэн сүйтгэх болон харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж буй алба хаагчийн амь бие, эрүүл мэндэд халдах хүртэл төлөвлөж санаатайгаар үйлддэг.

Оргон зайлзах гэмт хэргийн объект буюу хорих байгууллагын үндсэн үйл ажиллагаа, хамгаалалтын техник хэрэгсэлд



МОНГОЛ УСГЫН ХАГАЦААНЫ АДАМСААЛЫГ САЛГААХ АДЫГААНЫ СОХИЙН ТӨХӨӨН

тодорхой хэмжээний ноцтой аюул учирч, бодит аюул занал нүүрэлдэг.

Оргон зайлах гэмт хэргийн нийгмийн хор аюул нь дараах байдлаар илрэч болно. Үүнд:

1. Уг гэмт хэргийг үйлдсэн этгээд орох явцдаа бусдын бие махбодод халдан гэмтэл учруулахаар заналхийлэх, хүчиндэх, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, хулгайлал зэрэг гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр;

2. Оргон явцдаа харуул хамгаалалтын техник, тоног төхөөрөмжийг

эвдэн сүйтгэх, алба хаагчийн амь биед хүч хэрэглэн халдах, барьцаалах зэрэг ноцтой аюул учруулдаг. Орчин цагийн хорих байгууллагын түүхэн хөгжлийн 100 гаруй жилийн хугацаанд 19 алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байгаад амь насаа алдсанаас 9 нь хоригдлын үйлдсэн гэмт хэргийн улмаас алтан амиа алдсан харамсалтай тоо баримт байна (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, 2021);

#### **Шигтээ:**

1. Мааньт дахь чангага дэглэмтэй Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колониос 1980 оны 07 дугаар сарын 16-наас 17-нд шилжих шөнө хоригдол Ч.Дүгэрээ, н.Сугар нарын нэр бүхий 9 хоригдол харуул хамгаалалтын алба хаагчдад хүч хэрэглэн, галт зэвсэг, машин техник авч оргон зайлсан.

2. Авдрант дахь онцгой дэглэмтэй хорих ангиас 1996 оны 01 дүгээр сарын 03-наас 04-нд шилжих шөнө хоригдол Ч.Чулуунбаатар, Н.Лхагвасүрэн, Б.Төртогтох нар бүлэглэн 5 хүний амь насыг онц харгис хэрцгийгээр хөнөөн оргон зайлсан.


Дээрх 2 гэмт хэрэг үйлдэгдэх үед харуул хамгаалалтын алба хаагчид хууль, тогтоомжоор хүлээсэн албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, харуул хамгаалалтын хүчийг сулруулсан нь оргон зайлах гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3. Оргосон хоригдлыг эрэн сурвалжлах ажилд тухайн хорих ангийн алба хаагчдын 60-70 хувь нь хамрагдсанаар, тухайн хорих ангийн харуул хамгаалалтыг цөөн хүний хүчээр зохион байгуулж, хамгаалалтын хүч сулардаг, мөн ял эдлэгсдийн дунд "...одоо хорих анги чангарна, энэ хоригдлоос болж бид гадуур гарч чадахгүй боллоо..." гэх нийтийг хамарсан яриа өгүүлэл гарч, сэтгэл зүйн байдал тогтвортгүй болсноор хорих байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах эрсдэл үүсдэг;

4. Хоригдол оргосон талаарх

мэдээлэл нь "...нөгөө оргодол нь манай гэрт ороод ирвэл яана, охин хүүхдэд минь муу юм хийчих вий дээ, хурдан удмын ганц адууг минь унаад хол залгуулчих юм бии байгаа, эд хөрөнгөд минь аюул учрах вий..." гэх мэтээр нийгмийг айдаст автуулдаг зэрэг сөрөг үр дагаврыг бий болгодог.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад 2003-2022 оны хооронд хоригдол, хоригдогчийн зүгээс нийт 446 гэмт хэрэг үйлдэгдсэн (Алтангэрэл, 2019) ба үүнээс 309 буюу 69.3 хувь нь оргон зайлах гэмт хэрэг үйлдсэн байна.



Зураг 1. 2003-2024 онд үйлдэгдсэн оргон зайлах гэмт хэргийн судалгаа:



МОНГОЛ УУДААСАН ХУУЛЬ САХИУЛАХАЙ

Хэдийгээр сүүлийн жилүүдэд оргон зайлах гэмт хэргийн тоо буурсан үзүүлэлттэй байгаа боловч, таслан зогсоодоогүй байна.

Судлаачийн зүгээс өөрийн судалгааны ажлын үндсэн сэдэвтэй холбогдуулан хорих байгууллагаас оргон зайлах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, түүнд нөлөөлөх хүчин зүйлд хэсэгчилсэн дун шинжилгээ хийлээ.

Сүүлийн 5 жилд буюу 2020-2024 онуудад үйлдэгдсэн оргон зайлах 12 гэмт хэргийг сонгон авч, гэмт хэрэг үйлдэх болсон нөхцөл байдалд шинжилгээ хийж үзэхэд дараах нийтлэг шалтгаан, нөхцөл нөлөөлж байна. Үүнд:

**Нэг. Оргон зайлах гэмт хэргийн шалтгаан:**

- алба хаагчдын ёс зүй, харилцааны доголдол, хоригдолд үзүүлэх дарамт, шахалтын улмаас;

- хоригдлоос хорих ял эдлүүлэх ажиллагааны дэглэм, журам, цагийн хуваарь, хөдөлмөрлөх нөхцөлд дасан зохицож чадахгүйгээр шантрах, няцаж буй байдал;

- олон жилийн хорих ялын хугацаанаас шантардаг;

- үйлдсэн гэмт хэргийн шинж чанараас болж /бага насны хүүхэд хүчиндсэн болон бусад гэмт хэргийн төрөл хэлбэрээс/ бусад хоригдолд гадуурхагдсан, дарамтлуулсан;

- нийгмийн нөхцөл байдал;

- сэтгэл зүйн өөрчлөлт, тогтвортгүй байдал;

- эдийн засгийн нөхцөл байдал /ар гэр тарчиг, хомс/;

- гэр бүлд болон түүнд тулгарч буй бэрхшээл /ар гэрт тохиолдсон таагүй байдал буюу ойр дотнын хүн хүндээр өвдөх, нас барах, гэр бүл салалт гэх мэт/;

- ар гэрийн тааламжгүй байдлын талаарх бодит бус мэдээллийн улмаас /гэр бүлийн хүн нь хүндээр өвчилсөн, харилцаа холбоо тасарсан/ хардах;

- үр хүүхдийн ирээдүйн байдалд санаа зовсон;

- архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ;

- бусад хоригдлын ятгалгаар;

- байгаль, цаг уурын өөрчлөлт.

Оргох гэмт хэрэг үйлдэхэд дийлэнх нөлөөлдөг хүчин зүйл нь гэр бүл салалт, дотнын хүнээсээ хагацах, гэр бүлийн амьжирагааны дор байдал, хардалт зэрэг нь хоригдлын сэтгэл санаанд сөргөөр нөлөөлөх хамгийн том шалтгаан нь болж байна.

**Хоёр. Оргон зайлах гэмт хэргийн нохцол нь:**

- хорих байгууллагын харуул хамгаалалтын барилга, байгууламжийн стандарт, үйлдвэрлэлийн бүс болон бусад шаардлагатай газарт хийгдэж байгаа үйл ажиллагаа;

- алба хаагчдын хүрэлшээ муу;

- тусгай хэрэгслийн хангамж муу;

- алба хаагчдын нийгмийн баталгаа, цалин хөлс муу;

- алба хаагчдын сонор, сэрэмж, харилцаа хандлага, ёс суртахуун;

- алба хаагчийн мэргэжлийн ур чадвар сул;

- алба хаагчийн сургалт;

- удирдлага, зохион байгуулалт, дотоодын хяналт сул;

- хуулийн зохицуулалт, эрх зүйн орчин хангалтгүй зэрэг болно.

Хорих байгууллагын харуул хамгаалалт сул, албан хаагчийн ажлын хариуцлага, мэдлэг ур, чадвар муу, хоригдлыг гэрээгээр болон хэсэг салбарт ажиллуулах үед харуул хамгаалалтыг зөв зохион байгуулаагүй нь хоригдол хорих ангиас оргох гэмт хэрэг үйлдэгдэх гол нөхцөл болж байна.

Судалгаанаас хараад оргох гэмт хэрэг үйлдсэн 8 хоригдол нь хорих ангиин хамгаалалтын бүсээс гадна гэрээт хэсэг, салбараас оргосон нь гүйцэтгэх ажилтан, too бүртгэлийн байцаагч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарын хамтын ажиллагаа байхгүй, хоригдлын хувийн хэрэг, шийтгэх тогтоолтой огт танилцдаггүй, арга зүйн хурал, хоригдлын судалгааг нэр төдий хийж байгаа нь оргон зайлах гэмт хэрэг үйлдэгдэж байгаа нэг шалтгаан, нөхцөлийг бүрдүүлж буй хүчин зүйл юм.

Хорих ангиас оргох гэмт хэргийн 60-70 гаруй хувийг нээлттэй хорих ангиин



МОНГОЛ УСГЫН  
ХАРИУЦЛАГАТЫН  
ОДООГООР

аж ахуй болон гадна ажил хийж байх үедээ үйлдсэн байдлыг харгалzan хорих ангийн үйлдвэрийн чиглэл, төрөл, объектын ажлын байрны тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Оргон зайлах гэмт хэрэг үйлдэж буй хоригдол нь хорих ангийн хамгаалалтын бүсийн гаднах ажлын талбар болон салбар хэсгээс хавар, намрын улиралд шөнийн цагаар нийтлэг оргодог тул хоригдлыг хорих ангийн хамгаалалтын бүсээс гадуур ажиллуулах тохиолдолд хоригдлын талаарх мэдээллийг нарийн судалсны үндсэн дээр харуул хамгаалалтын хяналтад гаргаж байх нь зүйтэй юм.

Хоригдол, хоригдогчийн орлон зайлах гэмт хэрэг үйлдсэн нийтлэг шалтгаан нөхцөлд нөлөөлдөг хүчин зүйлийг судлан үзэхэд хамгаалалтын инженер-техник хэрэгсэл муу, албан хаагчийн ажлын хариуцлага сул, харуул хамгаалалтын алба хаагчдын хүрэлцээ муу, хоригдлын ажиллах ажлын байр, үйлдвэрлэлийн онцлог байдлыг сайн судлаагүй, нүд дассан байдлаар ханддаг, хоригдлыг илүү цагаар үзэгдэх орчин муу үед ажиллуулдаг зэрэг нь хоригдол оргон зайлах гэмт хэрэг үйлдэх нөхцөлд нөлөөлж байгаа дүр зураг харагдаж байна.

### Дүгнэлт

Хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад хоригдлын зүгээс гэмт хэрэг үйлдэхээр завдах, бэлтгэх, төлөвлөх нь буурахгүй байгаа нь хорих байгууллагын тайлан, мэдээнд дурдагджээ. Тэр дундаа оргон зайлах гэмт хэрэг ихэнх хувийг эзэлж байгаа нь энэхүү гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Иймээс гүйцэтгэх ажилтан, харуул хамгаалалтын алба хаагч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид сэтгэл зүйн хувьд тогтвортгүй хоригдлын ар гэрээс ирүүлсэн захидал харилцаанд хяналт тавьж, тухайн өдрийн ээлжийн бие бүрэлдэхүүнийг үүрэг чиглэлээр ханган, оргож болзошгүй хоригдлыг байнгын хяналтад байлгах хэрэгтэй.

Оргодол нь хорих ангийн хамгаалалтын бүсийн гаднах ажлын талбар болон салбар хэсгээс хавар, намрын

улиралд шөнийн цагаар нийтлэг оргож байгаа тул хорих ангийн хамгаалалтын бүсээс гадуур ажиллуулах тохиолдолд хоригдлын талаарх мэдээллийг нийгэм сэтгэл зүй, харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын зэрэг тал бүрээс нь нарийн судалж цугларсан мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хорих ангийн бүсээс гадуур ажилд гаргаж туршлагатай алба хаагчийн хяналтад ажиллуулах шаардлагатай гэж үзэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 245 дугаар зүйлийн 245.2 дахь хэсэгт “Хорих ангийн алба хаагч биечилсэн хамгаалалт, жиижүүрийн уургийг дөрвөн ээлжээр гүйцэтгэнэ” гэж заасан мөн жишиг нормативд 20 хоригдол тутамд 1 харуул хамгаалалтын ажилтан хяналт тавьж ажиллах зохицуулалттай боловч одоогоор алба хаагчдын орон тоог жишиг нормативд зааснаар нэмэгдүүлээгүй зарим хорих анги байгууллагууд харуул хамгаалалтыг турван ээлжээр зохион байгуулан ажиллаж байна.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив” (Хамтарсан тушаал, 2017)-аар нээлттэй, хаалттай хорих ангиудад 20 хоригдол тутамд 1, хаалттай хорих ангийн тусгай нэгжид 5 хоригдол тутамд 1, нийслэл дэх цагдан хорих төвд 10 хоригдогч тутамд 1, орон нутаг дахь цагдан хорих байруудад 20-50 хоригдогчтой бол 2 хамгаалалтын ажилтан биечилсэн хяналт тавихаар тогтоосон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хамгаалалтын ажилтан 937, холбоочин 72, дүрс бичлэгийн ажилтан 43, нийт 1052 ажиллаж байгаа ба “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”-аар тооцон үзвэл хамгаалалтын ажилтан 843, холбоочин 24, дүрс бичлэгийн ажилтан 181, нийт 1084 алба хаагчийг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн судалгааны дүн гарсан байна. (Хорих ял эдлүүлэх алба, Судалгааны тайлан, 2019)

Иймд хорих байгууллагын харуул хамгаалалтын алба хаагчдын хүний нөөц, ажлын ачааллыг хууль тогтоомжид заасан



МОНГОЛ УУДААСАН ХУУЛЬ САХИУЛАХУЙ

хүрээнд байлгах нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл хэрэгт томоохон байр суурь эзэлнэ гэж дүгнэлээ.

### Санал

Нийгэм, эдийн засгийн хөгжлийг дагаад хорих байгууллагын харуул хамгаалалт нь үйл ажиллагаандaa орчин үеийн техник, технологийн дэвшилийг ашиглаж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулж байгаа боловч хорих ангиас оргон зайлах гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Оргон зайлах гэмт хэрэгт оногдуулах ялын санкцыг хүндүүлэх эрх зүйн орчныг бий болгох;

2. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив” -д зааснаар хамгаалалтын ажилтны орон тоог нэмэгдүүлэх замаар оргон зайлах гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох орчныг бүрдүүлэх;

3. Хоригдлыг анх хорих ангид ангилан хуваарилах болон ял эдлэх үеийн сэтгэл зүйн байдалд хяналт тавьж, тогтмол оношилж, оргон зайлах гэмт хэрэг үйлдэх шалтгааныг арилгах нөлөөллийн цогц арга хэмжээг боловсруулах;

4. Хоригдлын бүхий л хөдөлгөөнд хяналт тогтоох зорилгоор хорих ангийн харуул хамгаалалтад цахим бугуйвч зүүлгэх эрх зүйн орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

5. Хорих ангийн албан хаагчийн мэдлэг, ур чадвар, хандлага, ажлын хариуцлагыг сайжруулах зорилгоор алба

хаагчдад оргох санаа бодол бүхий хоригдлын сэтгэл зүйн байдал болон оргон зайлах гэмт хэрэг үйлдэх шалтгаан, нөхцөлийг илрүүлэх, арилгах чиглэлээр мэргэшүүлэх болон давтан сургалтын модуль хөтөлбөр боловсруулах;

6. Цаашид хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр эрдэмтэн судлаачид, алба хаагчдаас бүрдсэн судалгааны багаар оргон зайлах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, нөлөөлөх хүчин зүйлийн талаар судалгааны ажлыг жил бүр боловсруулж практик үйл ажиллагаанд нэвтрүүлэх зэрэг болно.

### Ашигласан материал

Алтангэрэл, Б. (2019). *Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ (2003–2018)*. Улаанбаатар.

Хамтарсан тушаал. (2017). *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачаалал жишиг норматив*. Улаанбаатар.

Хорих ял эдлүүлэх алба. (2019). *Судалгааны тайлан*. Улаанбаатар: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар..

Хорих ял эдлүүлэх алба. (2020–2024). *Тайлан*. Улаанбаатар: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар..

Батболд, Ч. (2023). *Хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажил* (Докторын зэрэг горилсон бүтээл). Улаанбаатар: Дотоод хэргийн их сургууль.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. (2021). *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага* (Дэд боть). Улаанбаатар: Адмон Принт.